



Нээлттэй Нийгэм Форум

# ИРГЭН БА ТАТВАР

*(Татвар төлөгч иргэдэд зориулав.)*

Д. Дүгэржав  
Л. Бямбаа  
М. Алтангэрэл  
С. Цэмбэлмаа

Хянан тохиолдуулсан: Б. Пүрэвээ  
Б. Мөнхсоёл

DDC  
336.2  
И-788

## **НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ**

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48, Монгол Улс

Утас: 976-11-313207

Факс: 976-11-324857

Вэб хуудас: <http://www.forum.mn>

© Нээлттэй Нийгэм Форум 2004  
ISBN: 99929-0-329-5

Нээлттэй Нийгэм Форумийн зөвшөөрөлгүйгээр энэхүү номыг хэсэгчлэн буюу бүтнээр нь  
дахин хэвлэхийг хориглоно.

“ADMON” компанид хэвлэв.

Утас: 329253

## ИРГЭН ТАНЫГ ХӨТЛӨХИЙН УЧИР

Нээлттэй Нийгэм Форумаас бодлого боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог хөгжүүлэхэд эмжлэг үзүүлэх зорилгоор тодорхой сэдвүүдээр иргэдэд зориулсан гарын авлага боловсруулан гаргаж байгаа билээ. Энэхүү цуврал номын нэг болох “Иргэн ба татвар” гарын авлагыг Танд өргөн барьж байна.

Энэхүү гарын авлага нь юуны өмнө иргэн Танд татвар, түүнтэй холбоотой шаардлагатай мэдээллийг цогц байдлаар энгийн, ойлгомжтой, сонирхолтой хэлбэрээр хүргэхийг зорьсон юм. Гарын авлагаас иргэн Та яагаад татвар төлөх ёстой болох, татвар төлснөөр танд бий болох боломж болон төлөөгүйн улмаас гарах үр дүн, татвар төлөгчийнхөө хувьд ямар хуулиудийг нэн тэргүүнд мэдэх хэрэгтэй болох, татварын чухам ямар төрлүүд байдаг гэхчлэн Таны амьдрал, ажилд тустай төрөл бүрийн мэдлэг, мэдээллийг авч болно. Хуулийн хэллэг, татвар, түүнтэй холбоотой нэр томъёо, ухагдахууныг энгийн хялбар болгох үүднээс боломжит хэмжээнд олон жишээ, тайлбар, зураглалыг оруулж, татвар төлөгч ба бүх насны иргэдэд зориулан эрхэлж буй ажил, үйлчилгээтэй нь холбон тусад нь бүлэг болгон тайлбарлахыг хичээсэн нь уншигч Танд ач холбогдолтой байх болно хэмээн найдаж байна. Уг сэдвээр судалгаа хийдэг эрдэмтэн судлаач, оюутан сурагчид болон шийдвэр гаргагчид зэрэг энэ сэдвийг сонирхсон хэн бүхэн уг номыг ашиглах боломжтой юм.

Нээлттэй Нийгэм Форумын захиалгыг амжилттай гүйцэтгэж энэ гарын авлагыг Таны гарт хүргэх бололцоо олгосон Д. Дүгэржав ахлагчтай Хуульч эмэгтэйчүүдийн холбооны хамт олонд талархлаа илэрхийлье.

Энэхүү гарын авлагын чанар, агуулгатай холбоотой санал хүсэлтийг [osf@soros.org.mn](mailto:osf@soros.org.mn) хаягаар бид дуртайяа хүлээн авах болно.

П. Эрдэнэжаргал

Нээлттэй Нийгэм Форум  
Гүйцэтгэх захирал

## ӨМНӨХ ҮГ

Хүн төрөлхтөний нийгмийн хөгжлийн нийтлэг жаяг болох хүний эрх, эрх чөлөө, хуулиа дээдэлж шударгаар өрсөлдөх зах зээлийн харилцааг сонгож, асар их өөрчлөлт, шинэчлэл хийгдэж байгааг бид бүхэн өдөр тутам мэдэрч буй билээ.

Монгол Улсын Үндсэн хуульд хуулиар ногдуулсан албан татвар төлөх нь иргэний үндсэн үүрэг болохыг тогтоосон байдаг. Татвар нь хувийн өмч, орлогыг эзэн нь хүссэн ч хүсээгүй ч төрийн төсөвт албадан авч байдгаараа татвар төлөгчийн хувьд тийм ч сайхан сэтгэгдэл төрүүлдэг зүйл биш боловч гүнзгийрүүлэн сэтгэвээс эргээд бидний хэвийн амьдрах бүхий л нөхцөлийг хангахад зарцуулагддаг гэдгийг сайтар тунгаавал дайжиж зайлахын аргагүй чухамхүү Монгол Улсын иргэн гэдгээ эрхэмсгээр мэдрэх нэгэн сэжим билээ.

Монголын Нээлтэй Нийгэм Форумын санаачлагаар Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбооноос бэлтгэн Та бүхний гар дээр очиж байгаа энэхүү “Иргэн ба Татвар” гарын авлага нь иргэдийн татварын талаархи мэдлэгийг нэмэгдүүлэх, татварын чиг үүрэг, түүнийг төлөөгүйн төлөө хүлээх хариуцлагын талаар практик амьдралд илүү ойр дөт хэлбэрээр илэрхийлэн татвар төлөгч- иргэдэд туслахад чиглэсэн юм. Иргэн хүний хувьд ямар ямар татварыг юунд ногдуулж, хэдэн хувиар хэрхэн төлөх ёстой, бид татвараа төлдөггүй байсан бол ямар байх байсан тухайг тайлбарлахын зэрэгцээ татвар төлөгчийн хувьд эргээд төрийн үзүүлж байгаа үйлчилгээний чанар, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих иргэдийн хяналт, оролцоо чухал гэдэгт Таны анхаарлыг хандуулахыг зорьсон юм.

Гарын авлагыг боловсруулах ажилд МХЭХ-ны гишүүн-хуульч эмэгтэйчүүд өөрийн цаг, хөдөлмөрөө зориулсан юм. Энэхүү гарын авлагын 1-6, 10-15, 18-25, дахь сэдэв асуулт, хариулт, нэртомьёоны тайлбар, хавсралт хэсгүүдийг СЭЗДС-ийн багш, МХЭХ-ны гүйцэтгэх захирал Д.Дүгэржав, 8, 17, 20, 23 дахь сэдвийг Нийслэлийн шүүхийн шүүгч Л.Бямбаа, 7, 16, 21 дэх сэдвийг Төрийн албаны зөвлөлийн ажилтан М.Алтангэрэл, 9, 22, 24 дэхь сэдвийг МХЭХ-ны хуулийн зөвлөх С.Цэмбэлмаа нар боловсруулсан болно.

Нээлтэй нийгмийн идэвхтэй оролцогч-иргэн Та төсвийг бүрдүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулж байгаагаараа бахархахын зэрэгцээ та бүхний татвараараа

дамжуулан бүрдүүлсэн төсвийн хөрөнгийг хэрхэн ухаалгаар зарцуулж байгаа болон төрөөс Танд үзүүлж байгаа үйлчилгээний чанарт хяналт тавих, улмаар нийгмийн сөрөг үзэгдэл болох хүнд суртал, авилгалтай тэмцэхэд энэхүү гарын авлага хувь нэмрээ оруулж байвал бид бүхэн хамтын зорилгодоо хүрч байгаа нь тэр.

*Номын арвин буян дэлгэрэх болтугай.*

Багч овогтой Д.Дүгэржав

## Гарчиг

Өмнөх үг.....	4
1. Татвар гэж юу вэ? .....	8
2. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл нь татвар мөн үү? .....	11
3. Яагаад заавал татвар төлөх ёстой вэ? Түүнийг юунд зориулдаг вэ? .....	13
4. Татварын талаар Үндсэн хуульд юу гэж заасан байдаг вэ? .	15
5. Иргэн танд хамгийн түрүүнд мэдвэл зохих татварын ямар хууль тогтоомж байдаг вэ? .....	17
6. Бид татварын эдгээр хуулиудаас эрх ашигтаа нөлөөлөх гол хуулиа л сайн мэдсэн байхад хангалттай юу? .....	21
7. Иргэний орлого, татварын бүртгэл .....	24
8. Татвар төлөгчийн эрх, үүрэг .....	29
9. Татварын албаны талаар та юу мэдвэл зохих вэ?.....	32
10. Хувиараа аж ахуй эрхлэгч ба татвар.....	37
11. Хувьцаа, хадгаламж эзэмшигч ба татвар.....	44
12. Малчин ба татвар .....	46
13.Хөдөлмөрийн гэрээ бүхий ажилтан ба албан татвар .....	48
14. Ажил гүйцэтгэгч, хөлсөөр ажиллагч ба албан татвар.....	49
15. Гаалийн ба онцгой албан татварын тухай товчхон .....	51
16. Төрийн албан хаагч ба татвар .....	54
17. Тэтгэвэр, тэтгэмжээс татвар төлөх үү? .....	58
18.Та сугалаагаар машин хожлоо.....	59
19.Зохиогч, патент эзэмшигч ба татвар .....	61
20. Танд өв залгамжлалаар орон сууц өмчлөх эрх үүслээ.....	64
21. Орон сууц, хашаа, байшинтай хүн үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөх үү? .....	66
22. Хувийн машин ба татвар .....	70
23. Бууны албан татвар .....	74

24. Захиргааны шүүх ба татвар .....	77
25. Татвар төлөхгүй бол яах вэ? .....	81
Асуулт, хариулт.....	86
Нэр томъёоны тайлбар.....	95
Ном зүй .....	100
Хавсралт-1.Мэдээллийн төвүүдийн утас.....	101
Хавсралт-2.Зарим шаардлагатай маягтууд.....	103
Хавсралт-3.Хүн амын орлогын албан татварын хуулиас.....	108

# 1.Татвар гэж юу вэ?

Татварын тухай гүнзгийрүүлэн авч үзэхийн өмнө иргэн Жаргалд ямар асуудал тулгараад байгааг сонирхоцгооё. Иймэрхүү асуудал та бидэнд нэлээд түгээмэл тохиолддог гэдэгтэй маргах хүн цөөн байх.

Огноо: 2004/03/22

“Марс” ХХК

2004 оны 3 дугаар сарын цалин

Хэлтэс: Борлуулалтын алба

Нэр: С.Жаргал

Үзүүлэлтийн нэр

Утга

Үндсэн цалин	132000.00
Нэмэгдлийн дүн	34800.00
Олговол зохих	166800.00
Урьдчилгаа цалин	65000.00
Ажиллагчаас төлөх НДШ, ЭМД	16680.00
Орлогын татвар	11012.00
Суутгалын дүн	92692.00
Өөрт нь олгогдох дүн	74108.00

Гарын үсэг .....






Жаргалд үнэхээр татварын тухай мэдэх шаардлага тулгарсан байна. Түүний нийт авах байсан цалин, нэмэгдлээс сарын эхэнд авсан урьдчилгаанаас гадна ажиллагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэл /НДШ/, эрүүл мэндийн даатгалын шимтгэл /ЭМД/, орлогын татвар суутган авсан учир тэрээр төлөвлөж байсан хэмжээнийхээ мөнгийг хүлээн аваагүй нь тодорхой байна. Бид энэ гарын авлагаараа татвартай холбоотой хамгийн тулгамдсан асуудлыг мэдэж, амьдрал ахуйдаа хэрэглэж чаддаг болоход тань туслах болно. Эдгээр суутгалуудыг хэрхэн тооцож, ямар хувь хэмжээгээр, ямар журмаар төлөх ёстойг дараа дараагийн сэдвүүдээрээ авч үзэх болно.

Иргэн, хуулийн этгээд татвар төлж, улсын төсвийг бүрдүүлэх бөгөөд уг төсөв нь төр үйл ажиллагаагаа хэвийн явуулах, иргэддээ үйлчлэх санхүүгийн эх үүсвэр нь болдог. Энэ тухай бид 3 дахь сэдвээрээ илүү тодорхой авч үзэх болно.

Хуульд заасны дагуу таны орлого, эд хөрөнгө зэрэгт татвар ногдуулж, улс, орон нутгийн төсөвт оруулдаг. Татварын тогтолцоо нь албан татвар, төлбөр, хураамжаас бүрддэг.




Хууль тогтоомжийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлого, эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээнд тодорхой хугацаанд, тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг АЛБАН ТАТВАР гэнэ.

Жишээ нь, Жаргалын 2004 оны 3 дугаар сард авсан цалинд нийт 11012 төгрөгийн хүн амын орлогын албан татвар ногдуулж, тус компанийн нягтлан бодогч төсөвт оруулахаар суутгал хийжээ. Энэ тухай “Хүн амын орлогын албан татварын хууль”-д тодорхой заасан байдаг. Уг хуулиар хувь хүний ямар, ямар орлогод татвар ногдох, жинхэнэ татвар ногдох орлогыг яаж бодож гаргах, уг орлогоос, хэдэн хувиар тооцож, татвараа хэрхэн төлөх тухай заасан байдаг.

Хууль тогтоомжийн дагуу төрийн зохих байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлсний төлөө тэднээс тухай бүр авч улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг ХУРААМЖ гэнэ.

Жишээ нь, шүүхэд нэхэмжлэл гарган иргэний маргаанаа шийдвэрлүүлэхэд нэхэмжилж байгаа хөрөнгийн дүнтэй хамааруулан тэмдэгтийн хураамж төлдөг. Мөн шинээр аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага байгуулж улсын бүртгэлд бүртгэхэд хураамж төлдөг гэх мэт. Эдгээрийг тэмдэгтийн хураамж гэх бөгөөд “Тэмдэгтийн хураамжийн тухай” хуулиар зохицуулж байна.



Төрийн өмч /иргэдэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц зэрэг/-ийг ашиглуулсны төлөө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авч, улс, орон нутгийн төсөв, тусгай зориулалтын санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг ТӨЛБӨР гэнэ.

Жишээ нь, үйлдвэрлэл, шинжлэх ухааны зориулалттайгаар загас барихад килограмм тутамд 20-30 төгрөгийн төлбөр төлөх ёстой гэх мэт. Тухайн төрлийн төлбөрийг тогтоосон Монгол Улсын хуулиар зохицуулсан байдаг.

*Албан татвар, төлбөр, хураамжийн ижил ба ялгаатай талыг та ажигласан уу?*

Аль алийг нь хуульд заасны дагуу заавал төлөх ёстой байдгаараа адил байна. Харин албан татварыг хариу төлбөргүйгээр ногдуулдаг бол хураамжийг төрийн аль нэг байгууллага үзүүлж байгаа үйлчилгээнийхээ төлөө, төлбөрийг төрийн өмчийг ашигласны төлөө тус тус хураан авч байна.

Эдгээр мөнгөн хөрөнгийг улс, орон нутгийн төсөвт төлсөн тэр хэмжээгээр буцаан хүртэж байгаагаа татвар төлөгч мэдрэх боломжгүй бөгөөд тодорхой бус хугацаанд, тойруу замаар ямар нэг хэмжээгээр хүртэж л байгаа. Харин үүнийгээ хүн бүр мэдэрч, ухаардаггүй гэж хэлж болно.

## **2. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл нь татвар мөн үү?**

Хүмүүсийн хоорондын ярианд татвар, шимтгэл төлөх гэдэг утгаараа нийгмийн даатгалын шимтгэл нь нэг л төрлийн татвар юм гэсэн ойлголт давамгайлж байдаг. Гэтэл та бүхэн татварын тогтолцоог харуулсан схемээс тэнд шимтгэл хамаардаггүйг ажигласан байх.

**Эрүүл  
мэндийн  
даатгалын  
дэвтэр**

**Нийгмийн  
даатгалын  
дэвтэр**

Нийгмийн даатгалын шимтгэл бол таны ирээдүйд тохиолдож болох тодорхой эрсдлийн үед өөрт учирсан хохирлоо арилгуулах эх үүсвэртэй болох боломжийг хангаж өгдөг. Нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч /ажил олгогчийн төлөх хураамжийн тухай энд дэлгэрэнгүй авч үзээгүй болно/ болон иргэн хуульд заасны дагуу төлөх бөгөөд тухайн эрсдэл тохиолдоход та урьд нь өөрийн шимтгэлээрээ тодорхой хэмжээний хуримтлал бий болгосон тул даатгалын байгууллагаас учирсан хохирлоо арилгуулах боломжтой болно гэсэн үг.

Нийгмийн даатгал нь дараахь төрөлтэй байна:



Жишээ нь, хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдаж, эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх, жирэмсний болон амаржсаны дараа тэтгэлэг авах, мэргэжлээс шалтгаалах болон ердийн өвчний улмаас тахир дутуу болох, өндөр наслах гэх мэт хуульд заасан тохиолдолд та эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл төлж байсныхаа хувьд тэтгэвэр, тэтгэмж авах эрхтэй.

Эхний сэдэвт иргэн Жаргалын 2004 оны 3 дугаар сарын цалингийн хүснэгтийг тусгасан байгаа. Жаргалын авбал зохих нийт цалин, түүнтэй адилтгах орлогоос 10 хувь буюу 16680 төгрөгийг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлд суутгасан болох нь харагдаж байгаа. Нийгмийн даатгалын тухай хуульд зааснаар даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэврийн даатгалд 5,5 хувь, тэтгэмжийн даатгалд 1 хувь, ажилгүйдлийн даатгалд 0,5 хувийг байгууллагын захиргаа цалин олгох үедээ суутган нийгмийн даатгалын санд шилжүүлнэ. Мөн Монгол Улсын иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг Засгийн

газар тогтоох бөгөөд тухайн үед ажиллагчаас төлбөл зохих хэмжээг 3 хувиар тогтоосон байжээ. Иймд Жаргалын хөдөлмөрийн хөлс, нэмэгдлүүдийн дүнгээс нийт 10 хувийг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд суутган авсан байна.


Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч, төрийн албан хаагч нь заавал даатгуулах ёстойг хуульчлан заасан байдаг бөгөөд бусад иргэн үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлж байгаа бол нийгмийн даатгалд даатгуулах эсэх, түүний ямар төрлийг сонгохоо өөрөө шийдвэрлэнэ. Ингэж сайн дураараа даатгуулах бол даатгалын нөхцөлийг даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээр тодорхойлно.

Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлд зориулж цалин хөлснөөсөө зохих хэмжээгээр заавал суутгуулж байгаа нь татвартай адил мэт боловч зориулалтаараа ялгаатай байдаг. Татвар нь нийгэмд, нийт иргэдэд /үүний дотор татвар төлөгч ч бас багтана/ зориулагддаг бол нийгмийн даатгалын шимтгэлээр бүрдүүлсэн хөрөнгө бол зохих хугацааны дараа зөвхөн танд буюу танай гэр бүлийнхэнд зориулагдана. Ийм учир даатгалын тохиолдол /эрсдэл/ бий болсон үед авах тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нь даатгалд төлсөн мөнгөний хэмжээнээс шууд хамаарч байдаг. Даатгал огт төлөөгүй хүн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын сангаас хүртэх эрхгүй байдаг бол татвараар бүрдэж байгаа төсвийн хөрөнгө нь нийт иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээнд зориулагддаг байна.

Татварыг бид төрийн сан буюу төсөв гэдэг том сан руу хийдэг бол нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бид даатгалын санд төвлөрүүлдэг.

### **3.Яагаад заавал татвар төлөх ёстой вэ? Түүнийг юунд зориулдаг вэ?**

Та авах гэж тооцож байсан мөнгөнөөсөөсөө тодорхой хэмжээгээр татварт суутгуулахдаа дуртай биш байдаг байх. Гэвч татвар төлөх нь эргээд танд ямар ач тустайг одоо авч үзье. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлсөн татвар нь улс, орон нутгийн төсөвт орж, улмаар дахин хуваарилагдаж танд дараахь үйлчилгээг хүртэх боломж олгодог.



Та болон таны хүүхэд сургуульд сурч эрдэм боловсрол эзэмшихэд таны төлсөн татварыг зориулж байна.

Эмнэлгийн байгууллагын үйлчилгээг та хүртдэг үү? Уг үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай дийлэнх зардлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлж таны эрүүл мэндийг хамгаалж байна.

Төрийн бүх шатны байгууллага /Улсын Их Хурал, Засгийн газар, бүх шатны нутгийн захиргааны байгууллага, шүүх, цагдаа, прокурор гэх мэт/ та бидний татвараар санхүүжиж та бидний төлөө үйлчилж байна.

Эх орноо батлан хамгаалахад шаардлагатай бүх зардлыг бид төлсөн татвараараа санхүүжүүлж байна.

Бид татвараа төлдөггүй, эдгээр бүх үйлчилгээ байхгүй болчихлоо гээд төсөөлж болно. Хүүхдээ сургуульд өгөхөө больж, өөрөө заах буюу, хувийн багш хөлсөлнө. Өвдөж зовбол зөвхөн хувийн эмнэлгээр хөлсийг нь төлж үйлчлүүлнэ. Иргэний үнэмлэхээ авах гэтэл захиргаа байхгүй. Хэн нэг хүн таныг зодлоо гэхэд хамгаалах цагдаа байхгүй. Зээлсэн мөнгөө эргүүлж өгөхгүй байгаа нөхрөөс мөнгөө төрийн албадлагаар гаргуулаад авах гэтэл шүүх байхгүй, гадаадын хүмүүс олноороо орж ирж байгалийн баялаг, алт, мөнгийг ухаад авлаа гэхэд хил гааль, цэрэг, цагдаа байхгүй учир бид ямар ч хамгаалалтгүй байна гэсэн хэрэг.

Яагаад татвар төлөх хэрэгтэйг та лав мэдэж авсан байх. Бид төрийн төв болон орон нутгийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, сургууль, эмнэлэг зэрэг хүний амьдралд зайлшгүй хэрэгтэй үйлчилгээг авахын тулд татвараа төлж, төсвийг бүрдүүлж байна.

Ийнхүү үйл ажиллагааг нь санхүүжүүлж байгаа болохоор эдгээр бүх байгууллага бидний мөнгийг хэрхэн үр ашигтай, зориулалтын дагуу зөв зарцуулж байна, бидэнд төрийн үйлчилгээ үзүүлэхдээ

хир зэрэг чанартай, хүнд сурталгүй, ялгаварлалгүй, шударга хандаж байна гэдгийг асууж, хянах эрхтэй гэдгээ ямагт санаж байх нь зүйтэй. Төсвийн хяналтад иргэд хэдийчинээ сайн оролцоно, төрийн үйлчилгээ төдийчинээ боловсронгуй болно.

**ТАТВАР БОЛ ТӨРИЙН ОРШИН ТОГТНОХ ҮНДЭС МӨН. ЭНЭХҮҮ ҮНДСИЙГ БҮРДҮҮЛЭХЭД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛЖ БАЙГАА ТАТВАР ТӨЛӨГЧ ТА ТАТВАРЫН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТ ТАВИХ ЭРХТЭЙ.**


Төрийн бүх шатны байгууллагын албан тушаалтан, ажилтнууд бол татвар төлөгч-иргэн **ТАНД ҮЙЛЧИЛЖ БАЙНА**. Та энэ үйлчилгээний чанар, төсвийн зарцуулалтад хяналт тавихад оролцсоноороо төрийн зарим албан хаагчийн хүнд суртал, шударга бус хандлагатай тэмцэхэд хувь нэмрээ оруулж буй хэрэг юм.

## **4.Татварын талаар Үндсэн хуульд юу гэж заасан байдаг вэ?**


Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд хуулиар ногдуулсан албан татвар төлөх явдал нь Монгол Улсын иргэний үндсэн үүрэг гэдгийг заасан байдаг. Эндээс бид дараахь дүгнэлт хийж болно. Үүнд:

1. Татварыг зөвхөн хуулиар ногдуулдаг. Хэн дуртай албан тушаалтан хуульд заагаагүй татвар, хураамж , төлбөр бий болгож хурааж авах эрхгүй. Зарим байгууллага, албан тушаалтан төрөл бүрийн төлбөр хураамж бий болгосон тушаал шийдвэр гаргаж мөрдүүлэх явдал хааяа тохиолддог. Энэ бол хуульд нийцэхгүй. Тэр ч байтугай татвар бий болгох, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт бий болгож байгаа аливаа зохицуулалтыг зөвхөн татварын тусгай хуулиудаар тогтооно гэдгийг Татварын ерөнхий хуульд заасан байдаг. Энэ нь янз бүрийн салбарын хуулиудаар тухайн салбарын явцуу эрх ашгийн үүднээс татварын хөнгөлөлт, чөлөөлөлт бий болгох, эсхүл шинэ төрлийн татвар бий болгох явдлыг зогсоож, татварын нэгдсэн бодлого явуулах боломжийг хангаж байгаа хэрэг юм.





2. Хуулиар ногдуулсан татвар төлөх явдал нь Монгол Улсын иргэний үндсэн үүрэг учраас татвар төлөхөөс зайлсхийсэн аливаа үйлдэлдээ иргэн, аж ахуйн нэгж байгууллага хариуцлага хүлээх ёстой. Татвар төлөөгүйн төлөө хүлээх хариуцлагыг Татварын ерөнхий хууль болон татварын бусад хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Эрүүгийн хуулиар тодорхойлсон байдаг.



Энэ хүн энэ бодлоо хэрэгжүүлбэл эрх зүйн ямар үр дагавар үүсч, ямар төрлийн хариуцлага хүлээж болох талаар 25 дахь сэдвээс дэлгэрэнгүй уншаарай

Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 7-д зааснаар Улсын Их Хурал нь төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах онцгой бүрэн эрхтэй. Төрийн санхүү, төсөв, мөнгө зээлийн бодлого нь татварын бодлоготойгоо нягт уялдаа холбоотой. Засаг захиргааны нэгж болох нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагуудын хувьд ч гэсэн тухайн шатныхаа төсвийг батлах, хэрэгжилтийг зохион байгуулах, татварын орлогоо бүрдүүлэх ёстой болдог. Иймд төсөв, татварын асуудал нь иргэн бүрт хамааралтай.



## 5. Иргэн танд хамгийн түрүүнд мэдвэл зохих татварын ямар хууль тогтоомж байдаг вэ?


1992 онд Үндсэн хууль батлагдсаны дараа Улсын Их Хурал татварын багц хуулийг намрын чуулганаараа баталж мөрдүүлсэн юм. Үүнээс хойш уг багц хуульд нэлээд шинэчлэл, нэмэлт, өөрчлөлт оруулсан юм. Одоогийн байдлаар албан татвар, төлбөр, хураамжийн тухай, татвар төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай 20 гаруй хууль мөрдөгдөж байна. Тэр бүхнийг энд нурших нь тийм ч их ач холбогдолтой бус харин иргэн бүр мэдвэл зохих зарим хуулийг энд дурьдаж байна. Та бүхэн эдгээр хуулийг УИХ-ын албан ёсны хэвлэл “Төрийн мэдээлэл” сэтгүүл болон Үндэсний татварын ерөнхий газрын эрхлэн гаргасан татварын хууль тогтоомжийн эмхэтгэлүүдээс үзэж болно.



Хүн амын орлогын албан татварын хууль /1992 оны 12 дугаар сарын 14-ны өдөр батлагдаж, 1993 оны 1 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр болсон/



Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль /1992 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдаж, 1993 оны 1 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр болсон/



Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль/1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр батлагдаж, 1998 оны 7 дугаар сарын 1-нд хүчин төгөлдөр болсон/



Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хууль /2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр батлагдаж, 2001 оны 1 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр болсон/



Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хууль /1992 оны 12 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан/



Онцгой албан татварын хууль /1993 оны 1 дүгээр сарын 21-нд батлагдсан/




Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль /1996 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр батлагдаж, 1996 оны 7 дугаар сарын 1-нд хүчин төгөлдөр болсон/

Татварын байгууллага нь эдгээр хууль тогтоомжийг амьдралд хэрэгжүүлэх талаар тодорхой жишээ, тайлбар бүхий аргачлал, дүрэм, журам боловсруулан татвар төлөгчдийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авч байдаг. Бид энэ гарын авлагаараа эдгээр хуулийн зохицуулалтын талаар хамгийн түгээмэл тохиолдлыг түшиглэн танд ойлгомжтой хэлбэрээр тайлбарлахыг хичээсэн болно.

## 6. Бид татварын эдгээр хуулиудаас эрх ашигтаа нөлөөлөх гол хуулиа л сайн мэдсэн байхад хангалттай юу?

Компани удирдаж байгаа хүний хувьд Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын болон Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийг хамгийн түрүүн мэдэх хэрэгтэй байдаг бол хувиараа гадаадаас бараа оруулж ирж борлуулдаг хүний хувьд Гаалийн татварын тухай болон Нэмэгдсэн өртгийн албан татварын талаархи мэдлэг юу юунаас чухал байх жишээтэй.



Дорж иргэн-татвар төлөгчийн хувьд ямар төрлийн татвар төлдөг бол?

- Мал бүхий иргэний орлогын албан татвар
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
- Бууны албан татвар төлөгч гэдэг нь энэ өгүүлбэрээс шууд ойлгогдож байна.

Тэгвэл ямар хуулийн аль заалтын дагуу хэдэн төгрөгийн татварыг хэзээ, хэрхэн төлөх ёстой вэ? гэсэн асуултууд гарч ирнэ. Дараагийн сэдвүүдээр бид энэ болон бусад нилээд нарийн зүйлийн талаар авч үзэх болно.



Жишээ нь, та хүүгийнхээ сургалтын төлбөрт энэ жил 350000 төгрөг төлсөн гэж бодъё. Энэ тохиолдолд таны татвар ногдох орлогоос энэ дүн хасагдаж, та татварын хөнгөлөлт эдлэх ёстой. Та энэ эрхээ мэдэх үү? Та энэ эрхээ эдэлж, татварын тооцоо хийснээр урьд татварт илүү төлсөн мөнгөө буцаан авах боломжтой болдог. Үүний тулд ямар баримт материал бүрдүүлж, хаана хандах вэ?

Юуны өмнө сургалтын төлбөр хийсэн тухайн жилдээ багтааж, төлбөр төлсөн баримтаа бүрдүүлж, татвар тодорхойлох хуудсандаа тусгаж хүн амын орлогын албан татварын тайлангаа дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор татварын хэлтэст тушаах үедээ тооцоо хийж, зохих хөнгөлөлтөө эдлэх ёстой.

Та цалин, орлогоосоо тухай бүрд нь татвараа суутгуулаад явсан бол таны татвар ногдох орлогоос хуулийн дагуу 350000 төгрөг хасагдахад урьд төлсөн татвараа эргүүлэн авах буюу дараа оны төлөх татвартаа тооцуулах боломжтой болно. Та хамгийн бага орлоготой байсан гэж бодоход 10 хувь буюу 35000 төгрөгөө эргүүлж авах буюу дараа төлөх татвартаа тооцуулна гэсэн үг.

Энэ хөнгөлөлтийн талаар Хүн амын орлогын албан татварын хуулийн 9-р зүйлийн 1 дэхь хэсгийн 13-т заасан ба их, дээд болон тусгай мэргэжлийн сургуульд суралцсан хүүхдийн сургалтын төлбөрийн хувьд эдлэх хөнгөлөлт юм.

Дээр дурдсанаар та татвар төлөгчийн хувьд “Иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр”-ээ зөв хөтөлж, хугацаандаа “Иргэний орлого, татвар тодорхойлох хуудас”-аар татварын тайлангаа тушааж тооцоо хийж байхын ач холбогдлыг та ойлгож авсан гэж бодож байна.

Хэрэв та татварын тайлангаа хугацаанд нь татварын албанд өгөөгүй бол дээрх хөнгөлөлт эдлэх эрхээ алдана гэдгийг анхаараарай.

Гадаадаас тамхи, эсвэл автомашин импортоллоо гэж бодъё. Эсвэл архи үйлдвэрлэдэг үйлдвэр байна. Энэхүү импортлогч болон архи үйлдвэрлэгчдийн хувьд Онцгой албан татварын тухай хуулийг дагаж мөрдөх хэрэгтэй болно.

Газрын төлбөрийн тухай, Агнуурын нөөц ашигласны төлбөр, Ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай, Ус, рашаан ашигласны төлбөрийн тухай, Ойгоос түлээ, хэрэглээний мод бэлтгэж ашигласны төлбөрийн тухай, Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуулиуд байдаг.

Та ой, ус, ан амьтан, байгалийн нөөц ашиглаж байгаа бол эдгээр хуулиудад бас захирагдаж, төлбөр, хураамжаа төлж байх ёстой болно.

Та бүхэн татварын нэг л хуулийг сайн мэдсэн байхад хангалттай биш байна гэдгийг лав анзаарсан байх. Гэхдээ бүх хуулийг хүн бүр



цээжилсэн байх албагүй ч хуульчид, татварын албаны ажилтнуудаас асууж, зөвлөгөө авдаг байж болно шүү дээ.

Түүнчлэн татварын хуулиудыг хэрэгжүүлэх аргачлал, зөвлөмжүүдийг Үндэсний татварын ерөнхий газраас гаргадаг бөгөөд “Татвар төлөгч иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагад тусламж” цувралуудыг ҮТЕГ-аас үе үе шинэчлэн гаргаж татварын багц хууль, түүнийг хэрэгжүүлэх аргачлалуудыг багтаасан байдаг. Мөн Улсын дээд шүүх бол хуулийг хэрхэн ойлгох талаар албан ёсны тайлбар гаргадаг.

Бүх хууль Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргадаг “Төрийн мэдээлэл” сэтгүүлд хэвлэгддэг бөгөөд хууль ийнхүү ил тод, олон түмэнд нээлттэй байдаг учир хууль мэдэхгүй байсан гэдэг нь хууль зөрчигчийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болдоггүй. Энэ номд бид нийслэл, дүүрэг, бүх аймгуудын Татварын албаны лавлах утасны дугаарыг хавсралт-1-д оруулсан байгаа.

Иргэн Та татварын талаар ямар нэг асуудал гарвал эдгээр утсанд залгаж өөртөө шаардлагатай мэдээллээ аваарай.

## 7. Иргэний орлого, татварын бүртгэл

Зах зээл хөгжсөн дэлхийн аливаа улс орнуудын практикт иргэд нь орлого, татвараа өөрөө тодорхойлж төлдөг нийтлэг бөгөөд шударга зарчмыг баримталдаг.

Монгол Улсын Хүн амын орлогын албан татварын хуульд зааснаар

- Татвар ногдох орлого бүхий Монгол Улсын иргэн
- Монгол улсад орлого олж байгаа оршин суугч бус этгээд
- Монгол улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн татвар төлөгч байна.



## Иргэдийн орлогын татварыг хоёр аргаар ногдуулдаг


1) Иргэдэд уг орлогыг олгож байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хуульд заасан хувь хэмжээгээр ногдуулан суутган тооцож, төсөвт шилжүүлэх. Энэ нь орлогын ганцхан эх үүсвэртэй иргэнд хамаарах бөгөөд орлогыг олгож байгаа ААНБ-ын суутган тооцсон татварын дүн нь эцсийн тооцоо болно.

2) Иргэн орлого, татвараа өөрөө тодорхойлж, татвараа төлөх. Хуульд заасан хөнгөлөлтөө эдлэхийн тулд татвар төлөгч бүр орлого, татвараа тодорхойлж иргэний орлого татвар тодорхойлох хуудсаар тооцоо хийх шаардлагатай.




Иргэн тухайн оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ татварын албанд бүртгүүлж “Иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр” авах бөгөөд тухайн жилд олсон дараахь орлогын нийт дүнг тодорхойлж, иргэний орлого, татвар тодорхойлох хуудсаар татварын тооцоо хийнэ. Үүнд:

1) үндсэн ажлын газраас бусад аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл болон адилтгах бусад орлого олж буй дараахь иргэд, тухайлбал:



Үндсэн ажлаасаа гадуур их дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургуульд багшилж буй багш нар



Үндсэн ажлаасаа гадуур хувийн эмнэлэгт үзлэг, эмчилгээ хийж байгаа Клиникийн болон нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн нэгдэл, төв, амбулаторийн зөвлөх эмч нар

- Хувьцаат компаниудын Төлөөлөн удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүд
- Төрийн өмчийн хороо болон Үндэсний Аудитын газрын гишүүд
- Их дээд сургууль, коллежийн удирдах зөвлөлийн гишүүд
- Өмгөөлөгчид, нотариатчид
- Аж ахуйн нэгж байгууллагын төрөл бүрийн мэргэжлийн (хууль, эдийн засаг, санхүүгийн, техник, технологийн) орон тооны бус зөвлөхүүд гэх мэт.



2) бараа материал, түүхий эд худалдан орлого олж байгаа иргэд, тухайлбал- Аж ахуйн нэгж, байгууллагад хувиараа бараа, материал бэлтгэн нийлүүлж буй иргэд гэх мэт.

3) Аж ахуй эрхэлж орлого олж буй иргэд, тухайлбал,

Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа иргэний орлогын албан татварын

тухай хуульд заасан үр тариа болон хүнсний ногоо тариалах, гахай, тахиа тэжээх, гар урлал, алт мөнгөн эдлэл хийх, гэрийн эд хогшил засварлах, засал чимэглэл хийх, хувийн машинаар ачаа болон хүн тээвэрлэх, худалдаа хийх, үсчин, гар урлал, дархан мужааны ажил, төлбөрт тоглоом тоглуулах зэрэг ажил үйлчилгээ эрхлэн орлого олж байгаа иргэд.

4) Хөрөнгө түрээслүүлэн орлого олж байгаа иргэд тухайлбал:

- Хөдлөх эд хөрөнгө (үйлдвэрийн зориулалттай тоног төхөөрөмж, машин, механизм, тээврийн хэрэгсэл г.м)
- Үл хөдлөх эд хөрөнгө (байшин барилга, байгууламж, газар г.м) зэргийг бусдад ашиглуулсны төлөө орлого олж байгаа иргэд


5) Гадаад орнуудаас Монгол Улсад суугаа ЭСЯ, Олон Улсын байгууллагад болон гадаад орон, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөлд ажилладаг Монгол Улсын иргэд.

ҮНДЭСНИЙ ТАТВАРЫН АЛБА



Татвар төлөгч иргэний орлого  
татварын бүртгэлийн дэвтэр

Эдгээр иргэд орлого олох бүрдээ олсон орлого, түүнд хуулиар ногдуулан суутгасан татварыг Иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэртээ тухайн орлогыг олгож, татварыг суутган авсан байгууллагаар тэмдэглүүлж баталгаажуулна.



Тухайн орлогыг иргэнд олгож, татварыг нь ногдуулан суутган тооцож байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь суутган авсан татварыг дараа сарын 10-ны дотор төсөвт шилжүүлж, тайланг улирал бүр гарган хуульд заасан хугацаанд татварын албанд тушааж байх үүрэгтэй.

Ингэж орлого, татварын бүртгэлийн дэвтэр авч, олсон орлогоо тухай бүр тэмдэглүүлэн, төлсөн татвараа баталгаажуулснаар тухайн иргэн хуулиар олгогдсон дараахь хөнгөлөлтийг эдлэх эрхтэй болох юм. Үүнд:

Амьдран суух зориулалтаар өөрсдийн орлого болон Зээлийн хөрөнгөөр хувьдаа орон сууц худалдан авах, орон сууцны барилга барих, их дээд болон тусгай мэргэжлийн сургуульд сурч байгаа хүүхдийнхээ сургалтын төлбөр хийх зэрэгт зарцуулсан хөрөнгөтэй тэнцэх хэмжээний орлогыг тухайн жилийн татвар ногдох орлогоосоо хасаж тооцуулах

Хуульд зааснаас илүү хэмжээгээр татвар төлсөн бол буцаан авах буюу дараагийн татварт суутгуулан тооцуулах зэрэг.


Иргэний орлогод ногдуулсан жилийн албан татвараас 48,000 төгрөгийн албан татварыг хөнгөлдөг. Энэ тухай номын 18 дугаар сэдвээр илүү дэлгэрэнгүй авч үзэх болно.

Иргэн өөрийн орлогоо үнэн зөв тодорхойлж, хуулиар ногдуулсан татварыг төлнө гэдэг бол улс орныхоо өмнө Үндсэн хуульд заасан үүргээ биелүүлж, эх орныхоо хөгжил, дэвшилд өөрийн хувь нэмрээ оруулж байгаа нэр төрийн хэрэг юм. Иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр болон Иргэний орлого, татвар тодорхойлох хуудсыг та бүхэн энэ номын ХАВСРАЛТ-2-оос үзнэ үү.

## 8.Татвар төлөгчийн эрх, үүрэг

Татвар төлөгч Та татварын эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж байгаа нийгмийн харилцаанд оролцохдоо эрх эдэлж, үүрэг хүлээнэ.


### а/Татвар төлөгч Таны эрх:



Жишээ нь, та хуульд заасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх эрхээ хэрэгжүүлж чадаагүй бол энэ талаар харилцах татварын албандаа мэдэгдэж, илүү төлсөн татвараа эргүүлэн авах, эсхүл төлөх ёстой татвартаа суутган тооцуулж болно. Харин энэ эрхийг чинь эдлүүлэх талаар татварын албаны зүгээс арга хэмжээ авахгүй байвал хуульд заасан журмаар гомдлоо гаргах эрхтэй.

Татварын алба нь тухайн татвар төлөгч олсон орлогодоо татварын ногдуулалтаа зөв хийсэн болон хугацаандаа татвараа төлсөн эсэхийг шалгадаг. Татвар төлөгч нь татварын улсын байцаагчийн тавьсан актад тайлбар өгөх, үндэслэлийг нь сонсох эрхтэй. Татвар төлөгч өөрөө хуулиа сайн мэддэг, мэдэхийг эрмэлздэг байх байх тусам тэдний татварын байгууллагатай харилцах харилцаа нь хүндрэл бэрхшээлгүй харилцан ойлголцсон байж чадна.

Хуулинд хөнгөлөлт эдлэх хэд хэдэн нөхцөл байвал бүх нөхцлийг эдлэх эрх бий юу?



Үгүй. Хэд хэдэн нөхцлөөр хөнгөлөлт эдлэх тохиолдолд аль нэгийг нь татвар төлөгч сонгон эдэлнэ.

Татварын алба, түүний хууль бус үйл ажиллагаа, шийдвэрийн талаархи гомдлоо хаана гаргах вэ?

Татварын улсын байцаагчийн тавьсан актыг татвар төлөгч эс зөвшөөрвөл 14 хоногийн дотор аймаг, нийслэлийн татварын газар, хэлтсийн дэргэдэх татварын маргаан таслах зөвлөлд гомдлоо гаргана.

Аймаг, нийслэлийн татварын маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг үндэсгүй гэж татвар төлөгч үзвэл дээд шатны татварын маргаан таслах зөвлөл, эсвэл захиргааны хэргийн шүүхэд гомдлоо 14 хоногт гаргана.

Энэхүү гомдол нь татвар төлөхийг зогсоох үндэслэл болохгүй. Харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлд зааснаар шүүгч “шүүгчийн захирамж”-аар татвар төлөхийг түр зогсоож болно. Татварын маргааныг хэрхэн шийдвэрлүүлэх талаар бид хамгийн сүүлчийн сэдвээр тусгайлан авч үзэх болно.

## 6/ Татвар төлөгч Таны үүрэг



### Татвар төлөгчийн үүрэг

#### Нийтлэг үүрэг

- Татвараа үнэ зөв тодорхойлох
- Тогтоосон хугацаанд төлөх
- Татвар ногдуулах, төлөхтэй холбогдсон тооцоо, мэдээ, тайланг тогтоосон хугацаанд татварын албанд ирүүлэх
- Татвар ногдох эд хөрөнгө, эрхээ бусдын өмчлөлд шилжүүлсэн тухай баримтыг тухай бүр татварын албанд өгөх

Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэл гаргах

#### Тусгай үүрэг

- Татварын хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд татварын албанаас тавьсан шаардлагыг биелүүлэх
- Татварын албаны шалгалтын актыг зөвшөөрвөл гарын үсэг зурах, эс зөвшөөрвөл тайлбараа бичгээр гаргах
- Үйлвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор энэ тухайгаа татварын албанд мэдэгдэж, гэрчилгээнд тэмдэглүүлэх
- Эрх бүхий байгууллагаас авсан тусгай зөвшөөрлийг хувь хүн, хуулийн этгээдэд түрээслүүлэх буюу худалдвал харьяа татварын албанд мэдэгдэх

Өөрийн нэр, хаяг, тамга, тэмдэг, улсын бүртгэлийн гэрчилгээ, харилцах болон хувийн дансыг бусдад ашиглуулан татвараас зайлсхийх боломж олгохгүй байх

Татвар төлөгч бүрийн сахин биелүүлбэл зохих үүргийг НИЙТЛЭГ ҮҮРЭГ гэх ба харин тодорхой тохиолдолд үүсэх үүргийг ТУСГАЙ ҮҮРЭГ гэнэ.





## 9.Татварын албаны талаар та юу мэдвэл зохих вэ?




Татварын алба гэдэг нь татвартай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын тогтолцоо юм.


-Үндэсний татварын алба нь нэгдмэл төвлөрсөн удирдлагаар буюу дээд шатны байгууллагадаа доод шатны байгууллага нь захирагдаж ажилладаг.



## Монгол Улсын татварын албаны удирдлага зохион байгуулалт



## Үндэсний татварын ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалт



### Татварын албаны чиг үүрэг


- Татварын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих
- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлал гаргах
- Сургалт сурталчилгаа явуулах
- Улс орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх

### Татварын албаны бүрэн эрх

- Хуульд зааснаар татварын хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх
- Жишгээр татвар ногдуулах
- Татвараа төлөөгүй аж ахуйн нэгжийн харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох
- Төлбөл зохих татвар, хүү, торгуулийг хугацаанд нь төлөөгүй бол татвар хураах үйл ажиллагааг зохих журмын дагуу явуулах
- Илүү төлсөн татварыг суутгах, буцааж олгох
- Зөрчил гаргагчид хуульд заасан хариуцлага хүлээлгэх
- Доод шатны татварын албаны шийдвэр үндэслэлгүй бол хүчингүй болгох, өөрчлөх
- Шаардлагатай мэдээлэл, судалгаа, баримт бичгийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах

Дараахь асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах:  
Хууль тогтоомж ноцтой зөрчвөл татвар төлөгчийн

- Хууль тогтоомж ноцтой зөрчсөн татвар төлөгчийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг зогсоох
- Татвар төлөгч хориглосон үйл ажиллагаа эрхэлж олсон орлого, тоног төхөөрөмж, түүхий эд материалыг хураах
- Татвар төлөгч хориглосон үйлдвэрлэлийг зөвшөөрөлгүй явуулж олсон орлогыг хураах
- Хүчин төгөлдөр бус гэрээ хэлцлээр олсон орлогыг хураах
- Татварын улсын байцаагчид саад учруулсан, эсэргүүцэл үзүүлсэн, хохирол учруулсан гэм буруутай этгээдэд шийтгэл хүлээлгэх.



Татварын улсын байцаагч бол албаны үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх үүрэг бүхий төрийн захиргааны жинхэнэ албан хаагч юм.

**Татварын улсын байцаагчийн үйл ажиллагаандаа баримтлах зарчим**


- Хууль дээдлэх
- Бусдын нөлөөнд үл автах
- Татвар төлөгчийн хууль ёсны эрх ашгийг хүндэтгэх

**Татварын улсын байцаагчийн бүрэн эрх:**

Баримтад хяналт шалгалт хийх, лавлагаа, бичиг баримтын хуулбарыг үнэ төлбөргүй гаргуулах, баримт бичиг хураан авах

Татварын хууль зөрчигчид хуульд заасан захиргааны хариуцлага хүлээлгэх

Татвар төлөгчийн хөрөнгө, үйлдвэрлэл худалдааны нууцыг хадгалах



Орлого олох зорилгоор ашиглаж байгаа, татвар ногдуулах зүйл хадгалж байгаа татвар төлөгчийн байр, агуулахад нэвтрэн орж шалгалт тооллого үзлэг хийх

Аж ахуйн нэгж байгууллагын бусдад олгосон хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод татварыг суутгаж төсөвт төлөөгүй бол уг байгууллагын хөрөнгөөс нөхөн төлүүлэх

Хууль бус үйл ажиллагаа илэрвэл холбогдох байгууллагад мэдэгдэх



## ТАТВАРЫН УЛСЫН БАЙЦААГЧ НЬ:

- Татвар төлөгчийн хууль бус ажиллагааг нуух
- Татварын орлогыг хувийн зорилгод ашиглах
- Хээл хахууль авах
- Мэдэээлийн нууц задруулах зэргээр эрхээ хэтрүүлж, хууль зөрчвөл хуульд заасан хариуцлага хүлээнэ.

### Захиргааны хариуцлага

Татварын улсын байцаагчийн хууль зөрчсөн үйлдэл нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол захиргааны хариуцлага хүлээлгэнэ

### Сахилгын хариуцлага

- Сануулах
- Албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах
- Төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэн орох эрхгүйгээр халах

### Эд хөрөнгийн хариуцлага

Татварын улсын байцаагчид сахилгын болон захиргааны хариуцлага хүлээлгэсэн эсэхээс үл хамааран эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэж болно.

## Эрүүгийн хариуцлага

Татварын улсын байцаагчийн хууль зөрчсөн үйлдлийг Шүүх эрүүгийн гэмт хэрэг мөн гэж үзвэл Монгол улсын Эрүүгийн хуулийн 263 /эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулах/, 264/эрх мэдлээ хэтрүүлэх/, 268 /хээл хахууль авах/, 271/албан тушаалтан хуурамч бичиг баримт үйлдэх/, 272/албан үүрэгтээ хайнга хандах/ зүйлүүдэд заасан хариуцлага ногдуулна.

## 10.Хувиараа аж ахуй эрхлэгч ба татвар

Манай Үндсэн хуульд иргэн хувиараа аж ахуй эрхлэх эрхтэйг зааж, өмчийн бүх төрөл, хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална гэсэн байдаг. Хувийн өмчийн эрх бол хүний сурч боловсрох, зорчих цагаачлах, аж ахуй эрхлэх зэрэг бусад олон эрх, эрх чөлөөгөө хэрэгжүүлэх үндэс нь болдог.

Аж төрөх наад захын хэрэгцээгээ хангахаас эхлээд хувийн өмчөө арвижуулан баяжуулахад хувиараа аж ахуй эрхлэх явдал чухал ач холбогдолтой.

Хувиараа аж ахуй эрхлэн олсон орлогод татвар ногдуулахдаа үндсэн хоёр зарчмыг баримталж байна.



**Нэгдүгээрт**, газар тариалан, гахай шувуу, туулай, зөгийн аж ахуй болон бусад бүх төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ байнга эрхэлж, орлогоо анхан шатны бүртгэлд тусган татвараа тодорхойлж төлдөг

аж ахуй эрхлэгчдийн хувьд Хүн амын орлогын албан татварын хуульд зааснаар уг орлогоосоо баримтаар нотлогдож буй зардал, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, онцгой албан татвар, байгалийн нөөц ашигласны хураамж, төлбөрийг хассан зөрүүгээр татвар ногдох орлогоо тодорхойлно.

Дээр дурдсан нийт орлогоос хасагдах ЗАРДАЛ гэдэгт:

- түүхий эд, үндсэн болон туслах материал
- хагас боловсруулсан зүйл
- уур ус, эрчим хүч
- түлш, шатахуун
- сэлбэг хэрэгсэл
- сав, баглаа боодлын зардал
- түрээсийн болон банкны зээлийн хүүгийн төлбөр
- бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс
- томилолтын зардал
- эрүүл мэнд, нийгмийн даатгалын болон үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэл хамаарна.

Ийнхүү тодорхойлсон жилийн татвар ногдох орлогоосоо дараахь хувиар татвараа төлнө:

Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хувь, хэмжээ
0-2 400 000	10 хувь
2 400 001-4 800 000	240 000 төгрөг дээр 2 400 000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 20 хувийг нэмнэ
4 800 001, түүнээс дээш	720 000 төгрөг дээр 4 800 000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 30 хувийг нэмнэ

Аж ахуй эрхлэгчийн гэр бүлийн гишүүддээ олгосон хөдөлмөрийн хөлсийг нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн хэмжээтэй хувь тэнцүүлэн бодож зардалд тооцдог. Иймд гэр бүлийн гишүүддээ хөдөлмөрийн хөлс олгосон боловч нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй бол уг хөлс нь зардалд тооцогдохгүй гэсэн үг юм.

Аж ахуй эрхлэгч нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнээс өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулсан байвал тэдгээрийг зардалд тооцохгүй.



Албан татвар ногдуулах орлогоо тодорхойлоогүй буюу тодорхойлох боломжгүй бол албан татвар ногдуулах орлогыг байгаль, цаг уур, зах зээлийн нөхцөл, ижил үйлдвэрлэгчтэй харьцуулсан жишгээр татварын алба тодорхойлно.

**Хоёрдугаарт,** Хүмүүс хувийн машинаараа таксийн журмаар үйлчлэх, гутал тослох, ном худалдах зэргээр орлого олж, амьжиргаагаа залгуулах нь орчин үед их түгээмэл болсон. Ийнхүү аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй байгуулсан аливаа гэрээ, хэлцлээр зохицуулагдаагүй төрөл бүрийн ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч Монгол Улсын иргэн, Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга болон түр оршин суугч гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь албан татвар төлөгч байна.

Ийм хүмүүсийн хувьд тэр бүр орлогоо бүртгээд баримтжуулаад байх боломж ховор, бусдад хөлс олгох зэрэг төвөгтэй ажиллагаа шаарддаггүй бөгөөд түүний орлогыг өөрөөс нь өөр хэн ч тодорхойлох боломжгүй байдаг. Ийм тохиолдолд татвар төлөхтэй холбоотой харилцааг Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай Монгол Улсын хуулиар зохицуулж байна.

Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй дараахь ажил, үйлчилгээ эрхлэгч иргэний орлогод сар тутам ногдуулах албан татварын хэмжээг дор дурдсанаар тогтоосон байна.

	Ажил, үйлчилгээний төрөл	Улаанбаатар хотод	Налайх, Багануур, Дархан-Уул, Орхон Аймгийн төвийн сумдад болон байнгын ажиллагаатай боомттой сумдад	Бусад аймгийн төвийн сумдад	Бусад газарт
	А	1	2	3	4
1.	Уран зураг, баримал, сийлбэр, бэлэг дурсгалын зүйл, гоёлын зүйл, төрөл бүрийн тоглоом хийж худалдах	3000	2000	1000	500
	Чимэглэлийн болон тасалгааны ургамал, цэцэг тарьж худалдах	1200	900	600	200
	Бэлэг дурсгалын зүйлд дурсгалын үг бичих, засал хийх	2400	2000	1000	200
2.	Гэр ахуйн зориулалттай техник, багаж хэрэгсэл, эд хогшил засварлах	4500	3500	2500	1500
	Радио, телевиз засварлах	6000	4000	2000	1000
	Цаг засварлах	3000	2000	1000	500
3.	Дарханы үйлчилгээ:				
	- алт, мөнгөний - бусад	16000 8000	14000 7000	12000 6000	10000 5000
4.	Багшлах, давтлага өгөх, дасгалжуулах, эх бэлтгэх, материал олшруулах	2000	1600	1200	1000
5.	Гэрэл зургийн үйлчилгээ, захиалгаар кино зураг авах, дүрс бичлэг хийх, видео киноны хальс төлбөртэйгээр ашиглуулах, видео кино үзүүлэх	7000	5500	4000	2000
	Дуу бичлэгийн хальс төлбөртэйгээр ашиглуулах	2400	2000	1600	1000
	Дуу бичлэгийн хальс төлбөртэйгээр ашиглуулах	10000	6000	4000	1000
6.	Видео, аудио бичлэг хуулж худалдах				
	Төлбөрт тоглоом тоглуулах /бильярдаас бусад/	12000	9000	4500	3000



7.	Гутал, хувцасны засвар, үйлчилгээ: - засварлах, будах - оёж худалдах - гутал тослох	4000 6000 900	2800 4000 400	2400 3000 200	2000 2500 100
8.	Автомашин угаах	3000	2000		
9.	Ачаа тээш боох, ачиж буулгах, зөөж хүргэх үйлчилгээ  Ердийн хөсгөөр үйлчилгээ үзүүлэх	2800 5000	2000 3000	1200 1500	1000
10.	Бараа, түүхий эд хадгалах	15000	10000		
11.	ТҮЦ-д худалдаа хийх	6000	4000	2000	1000
12.	Лангуугаар худалдаа хийх	6000	4000	2000	1000
13.	Валютын худалдаа эрхлэх	25000	15000	10000	5000
14.	Мэрэг төлөг үзэх	1200	1000	800	400
15.	Жижиг худалдаа хийх /самар, жимс, сүү, тараг, айраг, зайрмаг, ном, сонин, сэтгүүл, түлээ, нүүрс, техникийн тос г.м./	2400	2000	1600	600

Та энэ хүснэгтээс иргэн хаана, ямар төрлийн аж ахуй эрхэлж байгаагаас шалтгаалан ямар хэмжээний татвар төлөх ёстойг төвөггүй мэдэж авсан байх. Жишээ нь, валютын худалдаа эрхэлж байгаа хүн бол сард Улаанбаатарт 25000 төгрөг, хилийн боомт газарт 15000 төгрөг, аймгийн төвийн суманд 10000 төгрөг, сумын төвд 5000 төгрөгийн татвар төлөх үүрэгтэй байна.



Энэ иргэн хөдөө аймгийн төвд радио, телевизор засварлах үйлчилгээ эрхэлдэг гэж үзвэл тэрээр сард 2000 төгрөгийн татвар төлөх ёстой гэдгийг Та энэ хүснэгтээ ашиглан амархан мэдэж болно.

Тухайн ажил, үйлчилгээг нэг сар хүртэл хугацаагаар эрхлэх тохиолдолд сард ногдуулах албан татварын хэмжээг тухайн сарын хуанлийн хоногт хувааж, дүнг уг ажил, үйлчилгээ эрхэлсэн хоногийн тоогоор үржүүлэн ногдох албан татварын хэмжээг тодорхойлдог журамтай.

Дээрх хүснэгтэд дурдсан ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэн нь тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд бүртгүүлж, албан татварыг бэлнээр буюу бэлэн бусаар төлж, энэ тухай гэрчилгээ авна. Уг гэрчилгээг ажил, үйлчилгээ эрхлэх үед ажлын байр болон тээврийн хэрэгсэлдээ ил байрлуулж, тогтоосон гудамж, талбайд болон хилийн боомтоор нэвтрэх үед биедээ авч явна. Гэрчилгээ нь нийслэл болон тухайн сумын нутаг дэвсгэр дээр хүчинтэй байна. Гэрчилгээнд заасан хугацааны ажил, үйлчилгээний орлогыг Хүн амын орлогын албан татварын хуульд заасан журмаар орлого, татвар тодорхойлох хуудсаар тооцох жилийн орлогын дүнд оруулахгүй. Учир нь гэрчилгээгээ авах үедээ татвараа урьдчилан төлсөн тул давхардуулан татвар ногдуулж болохгүй.

Харин дараахь үйлчилгээ эрхлэгч иргэний албан татвар ногдуулах орлогыг жишгээр тодорхойлох аргачлалыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, уг орлогод Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан /13 дахь сэдэвт хүснэгтээр үзүүлсэн/ хувь хэмжээгээр тооцож албан татвар ногдуулдаг.

Үүнд:

1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй байгуулсан аливаа гэрээ, хэлцлээр зохицуулагдаагүй автомашин болон тээврийн бусад хэрэгсэлд засвар, үйлчилгээ хийх
2. Барилгын засал, чимэглэл, засвар, үйлчилгээ хийх, зураг төсөл зохиох
3. билльард тоглуулах
4. гуанз, цайны газар, буфет, кафе, зуушны газар ажиллуулах
5. чингэлэг, тээврийн хэрэгсэл дээрээс худалдаа хийх
6. эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, эмийн худалдаа хийх
7. төрөл бүрийн хүнсний зүйл үйлдвэрлэж, худалдах
8. хот, сумын дотор автомашинаар зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ хийх, сум, аймаг, хот хооронд автомашинаар зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ хийх



Улс хооронд зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ хийх тухай бүрд дор дурдсан хэмжээгээр албан татвар ногдуулдаг:

Ажил үйлчилгээний төрөл	Албан татварын хэмжээ /төгрөгөөр/	
	Замын- Үүд, Алтанбулаг боомтоор	Бусад боомтоор
<b>1. Улс хооронд зорчигч тээврийн үйлчилгээ хийх тухай бүрд:</b>		
а/ 4 хүртэл хүний суудалтай автомашинаар	10000	6000
б/ 8 хүртэл хүний суудалтай автомашинаар	12000	8000
в/ 16 хүртэл хүний суудалтай автомашинаар	14000	10000
г/ автобусаар	18000	12000
<b>2. Улс хооронд ачаа тээвэрлэх үйлчилгээ хийх тухай бүрд:</b>		
а/ 1-3 тн-ын даацтай автомашинаар	16000	10000
б/ 3-5 тн-ын даацтай автомашинаар	18000	12000
в/ 5-8 тн-ын даацтай автомашинаар	20000	14000
г/ 8-аас дээш тн-ын даацтай автомашинаар	22000	16000
д/ трактораар	10000	4000

Автомашины суудлын хэмжээ, даац 2 ангилалд давхардсан тохиолдолд өмнөх ангиллаар тооцож албан татвар ногдуулна.

## 11. Хувьцаа, хадгаламж эзэмшигч ба татвар

Орлого олж байгаа бол татвар төлөх ёстой гэсэн үндсэн зарчим байдаг. Заримдаа үүнийг “Төрөх үнэн, үхэх үнэн, татвар төлөх үнэн” гэсэн хэлц үгээр илэрхийлэх явдал байдаг.



Та  
 банкинд хадгалуулсан  
 мөнгөнийнхөө хүүгээс 15 хувийн,  
 мөн “Говь” хувьцаат компаниас ногдол  
 ашиг авбал түүнийхээ 15 хувьтай  
 тэнцэх татвар төлөх үүрэгтэй.

Би ХААН  
 банкинд 20 сая төгрөгийн  
 хадгаламжтай “Говь” хувьцаат  
 компанийн 100 ширхэг хувьцаа  
 эзэмшдэг. Татварын талаар л асуух  
 гэсэн юм.

/Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5.б, 5 дугаар зүйлийн 5.3.д, 8 дугаар зүйлийн 8.4-д энэ тухай заасныг хавсралт 3-аас үзнэ үү/

Хувьцаа болон хадгаламж эзэмшигчийн төлбөл зохих татварын хэмжээг дээрх ярилцлагад харуулсан байна. Харин хүмүүсийн банкинд мөнгөө хадгалуулах сонирхлыг нэмэгдүүлэх болон хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор 2005 оны 1 дүгээр сарын 1 хүртэл хугацаанд зээлийн болон хадгаламжийн хүү, хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлогод ногдуулах албан татварыг авахгүй байхаар хуульд заасан юм. Татварын эрх зүйд үүнийг “татварын амралт” гэдэг.

Хуульд “хүүгийн орлого” гэсэн нэр томъёо байдаг. Энэ нь дээр дурдсан банк, зээлийн байгууллагаас авч байгаа хадгаламжийн хүүгээс гадна бусад олгосон зээлийн хүү, өрийн бичиг зэрэг үнэт цаасны хүү байж болно. Харин Засгийн газрын зээллэгээний хүүг татвараас чөлөөлдөг.

Хувьцаа эзэмшигч нь тухайн компани ашигтай ажилласан тохиолдолд хуульд заасны дагуу ногдол ашгаа хүртдэг. Харин нөхөрлөл, хоршоонд хөрөнгө оруулагчийн ашиг хуваарилах үед авч байгаа мөнгийг бид ногдол ашиг гэдэггүй, хувь хүртэгчийн орлого гэж нэрлэдэг. Мөн иргэд хуулийн этгээд байгуулахгүйгээр хамтран ажиллах гэрээ байгуулж, үр дүнд бий болсон ашгаа хуваарилдаг. Энэ мөнгийг бид мөн л хувь хүртэгчийн орлого гэж үздэг.

Хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлого, зээлийн болон хадгаламжийн хүүг олгож байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн нь хуульд заасан 15 хувийн суутгалыг хийж, иргэний орлого, татвар тодорхойлох дэвтэрт нь бичилт хийнэ. Тухайн байгууллага нь ийнхүү суутгасан мөнгөө дараа сарын 10-ны дотор төсөвт тушаана. Орлого олгохдоо ийнхүү суутгал хийгээгүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэн уг татварыг өөрөө төлж, мөн тэр хэмжээгээр торгууль хүлээнэ.

## 12. Малчин ба татвар

Малын мах, сүү, ноос, ноолуур зэрэг нь мал бүхий иргэний олж буй орлого юм. Орлого олж байгаа бол татвар төлөх зарчмын дагуу ямар хэмжээний татвар төлөх вэ? гэсэн асуулт тавигдана.



Хувийн мал бүхий иргэний албан татвар ногдуулах малын толгойн тоог хонин толгойд шилжүүлэн тодорхойлно. Татварын тооцоонд үхэр, адуу, тэмээ тус бүрийг 5 хонь, 1 ямааг 1.5 хонь гэж тооцно. Төсвийн жилд орлогын албан татвар ногдуулах малын тоог тодорхойлохдоо өмнөх жилийн эцэст тоологдсон малын тоог үндэс болгоно. /Хүн амын орлогын албан татварын хуулийн 6 дугаар зүйл/

Доржийнх хонин толгойд шилжүүлснээр хэдэн толгой малтай вэ? гэдгийг тооцож олъё.

$$50 \text{ хонь} + /50 \text{ ямаа} * 1,5 / + /20 \text{ үхэр} * 5 / + /15 \text{ адуу} * 5 / + /5 \text{ тэмээ} * 5 / = 325$$

Дурдсан хуульд ийнхүү тодорхойлсон хонин толгой буюу бог тутамд жилд дор дурдсан хэмжээгээр татвар ногдуулна.

Аймаг, нийслэл	Татварын хэмжээ /төгрөгөөр/
Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Улаанбаатар, Орхон	100
Архангай, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий	75
Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Завхан	50

Хүснэгтнээс үзвэл Өвөрхангай аймагт буй малчны хонин толгойд шилжүүлсэн буюу нэг богд ногдох татвар нь 75 төгрөг байна. Гэтэл Хүн амын орлогын албан татварын хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.7-д зааснаар мал бүхий өрхийн гишүүн тутамд 20 богийг татвараас чөлөөлөгддөг тул эдний 325 богоос /5 хүн\*20 бог=100 / 100 бог хасагдаж, Доржийнх нэг жилд /225 бог\*75төг=16875 төг/ 16875 төгрөгийн татвар төлөх юм байна.

Малчин энэ татвараа 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны дотор хоёр хувааж, мал сүрэг нь байнга байгаа нутаг дэвсгэрийн орон нутгийн төсөвт төлнө.

Та бүхэн одоо манай орны аль ч бүсэд байгаа мал бүхий иргэний тухайн жилд төлбөл зохих татварыг дээрх хүснэгтийг ашиглан тодорхойлж чаддаг боллоо.



## 13. Хөдөлмөрийн гэрээ бүхий ажилтан ба албан татвар

Хөдөлмөрийн гэрээ бүхий ажилтан гэрээнд заасан хэмжээний хөдөлмөрийн хөлс, бусад нэмэгдэл авдаг.

Долгор нэгэн үйлдвэрийн газарт ажилладаг. Үүнээс өөр газар ажилладаггүй гэж бодъё. Хүн амын орлогын албан татварын тухай хуульд зааснаар аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр үндсэн ажлын хэлбэрээр ажиллаж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, адилтгах бусад орлогоосоо татвар төлөх ёстой. Долгорын татвар ногдох орлого нь түүний авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, адилтгах бусад орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан зөрүүгээр тодорхойлогдоно.

Ийнхүү тодорхойлогдсон татвар ногдох орлогоосоо ямар хэмжээгээр татвар төлөхийг дараахь хүснэгтээс харж болно. Хүн амын орлогын албан татварыг тодорхойлохдоо жилийн нийт орлогод нь тодорхой хувиар татвар ногдуулдаг журамтай.

Монгол Улсад байнга оршин суугч татвар төлөгчийн татвар ногдох орлогын жилийн дүнд дараахь хэмжээгээр тооцож албан татвар ногдуулна.

Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хувь, хэмжээ
0-2400000	10 хувь
2400001-4800000	240000 төгрөг дээр 2400000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 20 хувийг нэмнэ
4800001, түүнээс дээш	720000 төгрөг дээр 4800000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 30 хувийг нэмнэ

Энэ талаар Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1-т заасан байна.

Дээрхи хүснэгтэд заасан хэмжээ нь татвар төлөгчийн дараахь төрлийн орлогод татвар ногдуулахад хамаарна:

### 1. цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого:

а/ аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр үндсэн ажлын хэлбэрээр ажиллаж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл тэтгэмж, адилтгах бусад орлого /нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалыг хассан зөрүүгээр/;



б/ үндсэн ажлын газраас бусад аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, адилтгах бусад орлого /дүнгээр нь/;

в/ тэтгэвэр, тэтгэврийн нэмэгдэл, тэтгэмж /дүнгээр нь/;

2.аж ахуй эрхэлсний орлого /уг орлогыг олохтой холбогдсон баримтаар нотлогдох зардал, татвар, төлбөр хураамжийг хассан зөрүүгээр/;

3.хувиараа бараа, материал, түүхий эд бэлтгэж борлуулсны орлого /баримтаар нотлогдох зардлыг хассан зөрүүгээр/;

4.хөрөнгийн хөдлөл, эрхийн орлогод хамаарах хөрөнгө түрээслүүлсний орлого /түрээслүүлэхтэй холбогдсон зардлыг хассан зөрүүгээр/, адилтгах бусад орлого.

Тухайн орлогыг олгож байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хөлс, орлогыг олгохдоо суутгал хийх замаар татварын мөнгийг авч үлдэн төсөвт тушаадаг. Ингэхдээ татварын албанаас гаргасан хүснэгтийг баримтлан суутгадаг бөгөөд иргэн жилийн эцэст үнэн зөв хөтөлсөн “Иргэний орлого, татварын бүртгэлийндэвтэр”-ээ үндэслэн татварын тайлангаа гаргахад ихэнх тохиолдолд татвар илүү төлөгдсөн байдаг. Учир нь татварын албаны гаргасан хүснэгт нь жилийн 12 сарын турш тухайн хэмжээний орлогыг сар бүр олдог байдлаар тооцсон байдаг тул зарим өндөр орлоготой сард /багш нарын хувьд илүү цагийн мөнгөө бодуулж авах, 13 дахь сарын цалин авах г.м/ илүү суутгал хийгдсэн байна гэсэн үг. Иймд хүн бүр орлого, татварын бүртгэлээ үнэн зөв хөтөлж, татварын тайлангаа жил бүр 2 дугаар сарын 10-ны дотор тушааж, эцсийн тооцоо хийж байх нь татвар төлөгчид ашигтай байдаг.

## **14. Ажил гүйцэтгэгч, хөлсөөр ажиллагч ба албан татвар**

Үндсэн ажлаасаа гадуур бусадтай ажил гүйцэтгэх, эсхүл хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажил хийж орлого олж байгаа ажил гүйцэтгэгч, хөлсөөр ажиллагч нар нь орлогоосоо Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 /13 дахь сэдвийн хүснэгт/-д заасан хэмжээгээр татвар төлнө. Практикт аж ахуйн нэгж, байгууллага ажил гүйцэтгэсэн, хөлсөөр ажилласны хөлсийг 10 хувиар тооцож, мөнгө олгох үедээ суутган авч, төсөвт тушаадаг.

Эдгээр хүмүүсийн хувьд хөдөлмөрийн гэрээгээр үндсэн ажлын журмаар авч байгаа хөдөлмөрийн хөлс, нэмэгдлээс ялгаатай нь эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг хасалгүйгээр нийт авч байгаа хөлснөөс дурдсан хувиар татвар тооцох нь түгээмэл байдаг. Гэхдээ Нийгмийн даатгалын тухай хуульд “иргэн үйлвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлж байгаа бол энэ хуульд заасан болзол, журмын дагуу нийгмийн даатгалд даатгуулах эсэх, түүний ямар төрлийг сонгохоо өөрөө шийдвэрлэнэ” гэж заасан байдаг тул үндсэн ажлаасаа гадуур бусадтай ажил гүйцэтгэх, эсхүл хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажил хийж орлого олж байгаа ажил гүйцэтгэгч, хөлсөөр ажиллагч хүсвэл эрүүл мэнд, нийгмийн даатгалд даатгуулж, орлогоосоо шимтгэлээ суутгуулж болно. Энэ нь тэдэнд даатгалын аливаа тохиолдлоос өөрсдийгөө хамгаалах нөхцлийг бүрдүүлэх ач холбогдолтой. Түүнчлэн даатгалд төлсөн шимтгэлийн хэмжээнээс даатгалын сангаас авах мөнгөний хэмжээ шууд хамаардаг гэдгийг дээр дурьсан болно.

Ажил гүйцэтгэгч, хөлсөөр ажиллагч нь өөрийн орлого, татварыг дэвтэртээ тэмдэглүүлж, жилийн эцсийн татварын тайлангаа гаргаж, харилцдаг татварын албандаа тушааж байх нь зүйтэй. Энэ үеэр тухайн үед суутгуулж байсан 10 хувийн татвар нь илүү буюу дутуу төлөгдсөн эсэхийг тодорхойлж зохих арга хэмжээ авагдах ёстой.

Таны орлого, татварын бүртгэлийн дэвтэр бол тухайн жилд таны авсан бүх орлого, түүнээс төлсөн татварын талаархи мэдээллийг агуулсан байх ёстой. Та орлогынхоо тухай мэдээллийг дутуу оруулах нь таныг илүү төлсөн татвараа буцааж авах эрхээ алдахад хүргэх сул талтай.

Татварын тооцоо хийх үед явцын дунд татвар дутуу төлөгдсөн нь тогтоогдож нэмж төллөө ч та Үндсэн хуульд заасан иргэнийхээ журамт үүргийг биелүүлж байгаагаараа бахархах ёстой.

Төрийн албан тушаалтнуудын хувьд орлогоо ийнхүү шударгаар тооцон татвараа төлснөөр өөрийн авилгалд өртөлгүйгээр төр, түмнийхээ төлөө ажиллаж байгааг нотлон харуулах толь нь болдог.

## 15. Гаалийн ба онцгой албан татварын тухай товчхон

Гаалийн татвартай холбоотой асуудлыг Гаалийн болон Гаалийн тарифын тухай хуулиар зохицуулдаг. Гаалийн татварын хэмжээг Улсын Их Хурлаас баталдаг бөгөөд одоогийн байдлаар гаалийн татварын хэмжээ 5 хувь байна. Гаалийн татвар тооцох үнэлгээг тогтоох хэд хэдэн аргачлалыг хуульд заасан бөгөөд түүнийг үндэслэн гаалийн байгууллага тодорхойлдог.

Иргэн гадаадаас бараа бүтээгдэхүүн оруулж ирэхдээ хил дээр гаалийн байгууллагад бараагаа мэдүүлэн татвараа төлөх ёстой. Ийнхүү импортолж байгаа бараандаа гаалийн татвараас гадна нэмэгдсэн өртгийн татварыг 15 хувиар төлнө. Импортын барааны гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг гаалийн байгууллага тухай бүр хураан авч, төсөвт оруулдаг.

Гаалийн татвараас чөлөөлөх барааны жагсаалтыг Гаалийн тарифын тухай хуульд заасан байдаг. Тухайлбал:

- Тахир дутуу хүмүүст зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, түүнийг үйлдвэрлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, түүхий эд;
- хүмүүнлэг, буцалтгүй тусламжийн бараа;
- зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл;
- гадаад орнууд дахь Монгол Улсын дипломат болон консулын төлөөлөгчийн газарт, түүнчлэн Засгийн газар хоорондын олон улсын байгууллагад нэг жилээс дээш хугацаагаар томилогдон ажиллаад эх орондоо бүрмөсөн буцаж ирж байгаа иргэний хувийн хэрэглээний суудлын автомашин /1-ээс илүүгүй/;
- эмчилгээний зориулалтаар хэрэглэх цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэн болон тэдгээрийн тохиороог баталгаажуулах, чанарыг алдагдуулахгүй хадгалах, тээвэрлэхэд шаардагдах оношлуур, урвалж, багаж, хэрэгсэл, сав, баглаа боодол гэх мэт.

Онцгой албан татвар нь зарим төрлийн бүтээгдэхүүний хэрэглээг хязгаарлах, татварын адил тэгш, шударга байх зарчмыг хангах зорилготой байдаг. Бүх төрлийн согтууруулах ундаа, бүх төрлийн тамхи, авто бензин, дизелийн түлш, суудлын автомашинд онцгой албан татвар ногдуулдаг.

Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн барааны онцгой албан татвар тооцох үнэлгээг уг барааг үйлдвэрлэгчээс борлуулсан

үнийг үндэслэн тодорхойлно. Харин импортоор оруулж байгаа бараанд онцгой албан татвар ногдуулахдаа тухайн барааны онцлогт тохирсон нэгж хэмжүүрийг тогтоодог.

Та бүхэн дараахь хүснэгтээс онцгой албан татварын хувь хэмжээг хэрхэн тодорхойлсныг харна уу.

Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл		Онцгой албан татварын хувь, хэмжээ		
		Эх орны үйлдвэрийн барааны		Импортын барааны нэгжид ногдуулах онцгой албан татвар /ам. долларт шилжүүлснээр/
		Онцгой албан татвар шингэсэн үнэлгээнээс тооцох онцгой албан татварын хувь	Нэгжид ногдуулах онцгой албан татвар /ам. долларт шилжүүлснээр/	
1. Хүнсний спирт		85	-	Литр тутамд 7.00
2. Архи	40хүртэл хатуулагтай	80	-	Литр тутмаас 5.00
	40-өөс дээш хатуулагтай	80		Литр тутмаас 6.00
3. Бүх төрлийн дарс		30	-	Литр тутмаас 0.75
4. Бүх төрлийн янжуур болон бусад тамхи		-	100 ширхэг тутмаас 0.30	100 ширхэг тутмаас 0.30
5. Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи		-	Кг тутмаас 0.15	Кг тутмаас 0.15
6. Пиво /2000.11.17-ий үнэмлэхүй /		-	литр тутмаас 0.20	литр тутмаас 0.20
7. автобезин/				
	90 хүртэл октантай	-	Тонн тутмаас 11.0	
	90-ээс дээш октантай	-	Тонн тутмаас 12.0	
8	Дизелийн түлш	-	Тонн тутмаас 15.0	

Эх орны үйлдвэрийн хүнсний спирт, бүх төрлийн архи, дарсанд ногдуулах онцгой албан татварын хувь хэмжээг уг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн ашигт ажиллагааны түвшин, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, хэрэглээний байдлыг харгалзан Засгийн газар 20 хүртэл нэгжээр хорогдуулах эрхтэй байдаг.



Импортын суудлын автомашинд түүний үйлдвэрлэгдэн гарснаас хойшхи хугацааг харгалзан автомашин тутамд дараахь хэмжээгээр / ам.долларт шилжүүлснээр/ онцгой албан татвар ногдуулна:

Үйлдвэрлэгдэн гарснаас хойшхи хугацаа	Татварын дүн /ам.доллараар/
0-3 жил	500
3-аас 10 жил	1000
10-аас дээш жил	2000

Зарим төрлийн барааг онцгой албан татвараас чөлөөлөхөөр хуульд заасан байдаг. Үүнд:


- Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэж экспортод гаргасан бараа;
- эх орны үйлдвэрийн пиво;
- гэрийн нөхцөлд энгийн аргаар нэрсэн шимийн архи;
- хамрын тамхи;
- гаалийн байгууллагаас зорчигчдод татваргүй нэвтрүүлэхийг зөвшөөрсөн хэмжээний хувийн хэрэглээний архи, тамхи;
- гадаад орнууд дахь Монгол Улсын дипломат болон консулын төлөөлөгчийн газар болон Засгийн газар хоорондын олон улсын байгууллагад нэг жилээс дээш хугацаагаар

томилогдон ажиллаад эх орондоо бүрмөсөн буцаж ирж байгаа иргэний хувийн хэрэглээний суудлын автомашин /1-ээс илүүгүй/ гэх мэт.

## 16.Төрийн албан хаагч ба татвар


Хуулийн дагуу татвар ногдох орлого, эд хөрөнгө, тодорхой эрх бүхий, эсхүл эд хөрөнгө эзэмшин ашиглаж байгаа дараахь иргэн, аж ахуйн нэгж, байгууллага татвар төлөгч байна:

- Монгол Улсын иргэн;
- Тус улсын нутаг дэвсгэрт оршин сууж байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, Монгол Улсад орлого олж байгаа оршин суугч бус этгээд;
- Тус улсын нутаг дэвсгэрт оршин байгаа дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, сан, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин байрладаггүй боловч тус улсад орлого олж байгаа хуулийн этгээд;
- Тус улсад орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчийн газар.



Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 11.1-д “Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ” гэж заажээ.


Төрийн албаны тухай хуульд зааснаар төрийн албан тушаалыг:



гэж ангилдаг бөгөөд цалин хөлс, нэмэгдэл нь хуулиар зохицуулагддаг

### Төрийн улс төрийн албан тушаалд:

- Монгол Улсын Ерөнхийлөгч
- Монгол Улсын Их Хурлын дарга
- Монгол Улсын Ерөнхий сайд
- Монгол Улсын Их Хурлын дэд дарга, гишүүн
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
- Дэд сайд
- Ерөнхий сайдын зөвлөх
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх
- Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга
- Бүх шатны Засаг дарга
- Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүн
- Улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтны албан тушаал
- Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаал хамаарна



*Улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцлийн, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ.*

### **Төрийн захиргааны албан тушаалд:**

- Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, шүүх, Үндсэн хуулийн цэц, прокурорын байгууллагын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны албан тушаал;
- Монгол банк, Үнэт цаасны хорооны болон Үндэсний статистикийн газрын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Монгол Улсын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн;
- Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал зэрэг Төрийн албаны тухай хуулийн 7.1-д заасан албан тушаал хамаарч байна.



**Төрийн захиргааны албан хаагчийн цалин хөлс нь** албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдлээс бүрддэг.

**Тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлс нь** албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн нэмэгдлээс бүрддэг.


### **Төрийн үйлчилгээний албан тушаалд:**

- төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал
- боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг зэрэг төрийн үйлчилгээний төсөвт байгууллагын удирдах ба гүйцэтгэх, туслах албан тушаал;
- Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллага болон хуульд өөрөөр заагаагүй бол аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх нутгийн захиргааны байгууллагын удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- яам, тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсөвт байгууллагын удирдах ба гүйцэтгэх албан тушаал зэрэг төрийн байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслахаар хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр авч ажиллуулах дараахь албан тушаал хамаардаг.

**Төрийн албан хаагч иргэн нь** төрийн байгууллагад ажиллаж, зохих хууль тогтоомжийн дагуу авч байгаа цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж зэрэг орлогоосоо *нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр* албан татвар ногдох орлогыг тодорхойлж, Хүн амын орлогын албан татварын хуульд заасан нөхцөл, хувь хэмжээгээр албан татвар төлнө.

*Хөдөлмөрийн хөлс гэдэгт* лекц яриа хийсэн, цагаар хичээл заасан, албан тушаал түр орлон гүйцэтгэсэн, гэрээгээр гүйцэтгэсний хөлс зэрэг орно.

Төрийн албан хаагч нь эдгээр бүх орлогын жилийн дүнд тохирох хэмжээгээр тооцож татвар төлнө.



Тухайлбал, Төрийн захиргааны албан хаагч Т.Зориг үндсэн ажлын зэрэгцээ лекц, яриа хийх, хичээл заах, сонин, хэвлэлд сэдэв бичих, ном зохиол туурвих зэргээр олсон жилийн орлого нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хасаад, 2 сая 400 мян. төгрөгнөөс бага байвал нийт дүнгээс 10 хувиар татвар төлнө.

Харин орлогын жилийн дүн энэ хэмжээнээс давбал Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан хувь хэмжээгээр татварыг бодож төлөх юм.

## 17. Тэтгэвэр, тэтгэмжээс татвар төлөх үү?

Өмнөх сэдвүүдээр тэтгэвэр, тэтгэмж нь цалин, хөдөлмөрийн хөлстэй адилтгах орлогод хамаарч татвар ногддог болохыг та анзаарсан байх.



Тэтгэвэр, тэтгэмжийн дүнд нь Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1-д /13 дахь сэдэвт үзүүлсэн хүснэгт/ заасны дагуу татвар ногдуулна. Та өндөр настай хүмүүс тэтгэвэр, тэтгэмжээсээ татвар төлдөггүй, тогтоогдсон мөнгөө бүрнээр нь л авдаг шүү дээ гэж бодож байгаа байх. Тийм ээ, тэд тогтоогдсон тэтгэврээ ихэвчлэн бүрэн авдаг. Тэр байтугай бага цалинтай хүмүүсийн хөдөлмөрийн хөлснөөс татвар авдаггүй.


Яагаад гэвэл Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т зааснаар дээр дурдсан хүснэгтээр үзүүлсэн орлогод ногдох жилийн татвараас 48000 төгрөгийн татварыг хөнгөлдөг. Энэ нь сард дунджаар 4000 төгрөгийн татвараас татвар төлөгч чөлөөлөгдөнө гэсэн үг юм.

Тухайн иргэний жилийн татвар ногдох орлого нь 2400000 буюу сарын орлого нь 200000 төгрөгт хүрэхгүй бол уг орлогоос 10 хувийг татварт төлөх ёстой, энэ бол хамгийн доод талын хувь. Иймд сард 4000 төгрөгийн татвар ногдуулж болох орлого бол 40000 төгрөг гэсэн үг. Иймд сард авдаг тэтгэвэр, тэтгэмж нь 40000 төгрөгт хүрэхгүй байгаа хүмүүс Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасан хөнгөлөлтийг эдэлж, татвараас чөлөөлөгддөг тул, түүний орлогоос суутгал хийх шаардлагагүй гэсэн үг юм. Ихэнх хүмүүсийн тэтгэврийн мөнгө нь 40000 төгрөгөөс илүү гардаггүй тул тэд татвар төлөхгүй байгаа мэт санагддаг. Гэтэл үүнээс илүү өндөр тэтгэвэр авдаг хүмүүс татвараа төлж л байгаа хэрэг юм.

Өөрөөр хэлбэл, сард авдаг тэтгэвэр, тэтгэмж, цалин нь 40000 төгрөгт хүрэхгүй байгаа хүмүүс Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасан хөнгөлөлт эдэлж, татвараас чөлөөлөгддөг.

## **18.Та сугалаагаар машин хожлоо...**

Энэ гарчгийг уншаад “Миний машин хожих татвартай ямар хамаа байнаа” гэж бодогдсон байх. Ямар нэг үнэ цэнэ бүхий зүйл сугалаагаар хожиж байгаа бол татварын ямар асуудал үүсдэг тухай авч үзье.



Азтанаар тодрох сайхаан. Гэхдээ азтан ч гэсэн иргэнийхээ үүргийг биелүүлнэ.

Хүн амын орлогын албан татварын тухай хуульд зааснаар бооцоот болон тааварт тоглоом, хонжворт сугалааны хонжворын орлогод түүний дүнгээр тооцож, 10 хувиар татвар ногдуулдаг. Таны хожсон машин 11 сая төгрөгийн үнэтэй гэж үзвэл 1100000 төгрөгийн татвар төлсний дараа та машины жинхэнэ өмчлөгч болно гэсэн үг.

Уг хонжворыг олгож байгаа газар “Танд баяр хүргэе, та татвараа төлж ирээд машинаа аваарай” гэж хэлэх болно.

Хурдан морины уралдаанд хүмүүс бооцоо тавьж, түрүүлсэн буюу айргийн тавд ирсэн морины эзэд бооцоогоо авдаг, мөн телевизийн төрөл бүрийн тааварт нэвтрүүлэгт оролцон хонжвор авч байгаа хүмүүс бүгд авч байгаа мөнгөн хөрөнгө, бусад эд хөрөнгийн үнийн 10 хувьтай тэнцэх хэмжээний татвар төлөх үүрэгтэй.


Энэхүү татварыг тухайн бооцоо, хонжворыг олгож байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэн суутган авч төсөвт тушаах үүрэгтэй байдаг.

## 19. Зохиогч, патент эзэмшигч ба татвар

Хүн амын орлогын албан татварын хуульд “эрхийн шимтгэлийн орлого” гэсэн нэр томъёо байдаг. Энэ нь зохиогчийн эрх, программ хангамж, патент, зураг төсөл, загвар, барааны тэмдэг, ноу-хау болон кино, видео бичлэг, аудиобичлэг, бусад төрлийн бичлэг ашигласны буюу ашиглах эрх эдэлсний төлбөр юм.

Эдгээр орлогоос ямар нэг хасалт хийлгүйгээр нийт дүнд нь 10 хувийн татвар ногдуулдаг.

Зохиогч нь бүтээлээ бусдад ашиглуулж, шагнал авах эрхтэй.




Хөгжмийн зохиол бол зохиогчийн эрхэд хамаарах бүтээл байдаг. Хөгжмийн зохиолч С-ийн хийлд зориулсан бүтээлийг дуурийн театр тоглолтдоо ашиглах зөвшөөрлийг С-ээс авсныхаа төлөө түүнд 200000 төгрөгийн төлбөр төлсөн бол тэрээр 10 хувиар тооцож, 20000 төгрөгийн татвар төлж, гар дээрээ 180000 төгрөг авах болно.

Түүнчлэн шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл зохиогч, шинэ бүтээл, оновчтой санал гаргагч, загвар зохион бүтээгчийн шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлогод татвар ногдуулна. Уг орлогын дүн нь 5 сая хүртэл төгрөг байвал 5 хувиар, 5 саяас дээш байвал 10 хувиар бодож татвар ногдуулна.



Жишээ нь, зохиолч Б-гийн туурвисан романыг нэгэн хэвлэлийн компани олон зуун хувиар хэвлэн борлуулж, зохиогчийн шагналд Б-д 6 сая төгрөг өгсөн бол Б-гийн төлөх татвар нь 10 хувиар бодогдож 600000 төгрөг болох бөгөөд түүний гар дээр 5400000 төгрөг ирнэ. Хэрэв 5 сая төгрөгийн шагнал өгсөн бол Б орлогоосоо 5 хувиар буюу 250000 төгрөгийн татвар төлж, гар дээрээ 4750000 төгрөг авах болно.



Сандаг элдэв шархыг маш богино хугацаанд эдгээх үйлчилгээтэй нэгэн эмийг гаргаж авах технологийг боловсруулж, оюуны өмчийн газраас шинэ бүтээлийн патент авчээ. Эмийн үйлдвэр уг технологио ашиглах онцгой эрхийг манай үйлдвэрт өгөөч, бид уг эмийг үйлдвэрлээд борлуулалтын орлогынхоо 0,3 хувийг шагнал болгон, танд тогтмол өгч байя гэсэн санал тавьжээ. Сандаг тэр саналыг хүлээн авсан. Энэ тохиолдолд Сандагийн төлөх татварын хэмжээ 5 хувиар бодогдох уу? 10 хувиар бодогдох уу? гэдэг нь тодорхойгүй байна. Харин шагналыг бодож олгох үед бодитоор хэдэн төгрөгийн шагнал авч байгаагаас энэ нь шалтгаална гэж ойлгох хэрэгтэй.

Манай өнөөгийн практикт зохиогчийн бүтээлийг хүлээн авч хэвлэлийн бүх санхүүжилт, борлуулалтыг нь хариуцаж, хэвлэх эрх олгосных нь төлөө зохиолчид шагнал өгдөг хэвлэлийн газар байхгүй байна. Иймд ном зохиолоо бичиж, хэвлүүлэх, борлуулах бүх зардлаа өөрөө хариуцаж байгаа зохиогчдын хувьд зохиогчийн эрхийн шагналаас татвар авдаг одоогийн хуулийн зохицуулалт нь тохирохгүй байгаа юм.

Сүүлийн жилүүдэд татварын албаны хийсэн шалгалтын акт, татвар ногдуулж байгаа практикаас үзвэл ийнхүү бүтээлээ туурвиж, өөрийн зардлаар номоо хэвлүүлэн борлуулж байгаа зохиогчдоос




хувиараа бараа, материал борлуулагчийн адилаар номын борлуулалтын орлогоос 3 хувийн татвар ногдуулах буюу зарим тохиолдолд үндсэн ажлын газраас бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил үүрэг гүйцэтгэж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, адилтгах бусад орлогын нэгэн адилаар номоо борлуулсан нийт орлогоос нь 10 хувийн татвар авч байгаа нь хуулийн заалттай нийцэхгүй байгаа юм. Иймд практикт нийцүүлэн хуулийг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Энэ гарын авлагыг уншиж байгаа Та бүхэн ч энэ талаар саналаа хэлэх байх гэж найдаж байна.

## 20.Танд өв залгамжлалаар орон сууц өмчлөх эрх үүслээ...

Танд орон сууц өмчлөх эрх үүсэх тохиолдолд тухайн эрх нь хуульд заасан үндэслэлээр үүсч байна уу? гэдэг хуулийн ойлголтыг Та мэдсэн байх шаардлагатай.

Иргэний хуульд зааснаар



Энэ хоёр үндэслэлийн аль нэгээр Танд өв залгамжлалаар орон сууц өмчлөх эрх үүсвэл:

Та өвлөх эрхийн гэрчилгээ авах ёстой /Иргэний хуулийн 531 дүгээр зүйлийн 531.1 дэх хэсэг/





Өвлөх эрхийн гэрчилгээ олгох хүсэлтийг өв нээгдсэн газрын нотариат, нотариатгүй бол сумын Засаг даргадаа гаргана.

Өвлөх эрхийн гэрчилгээ



Олгох хугацаа байна уу?

Хууль ёсны өмчлөгчид өвлөх эрхийн гэрчилгээг өв нээгдсэнээс хойш нэг жил өнгөрсний дараа олгоно. Харин өвлөгдсөн хөрөнгийг авах тухай хүсэлт гаргасан буюу хүлээн авсан этгээдээс өөр өвлөгч байхгүй нь нотлогдвол заавал 1 жилийн дараа гэрчилгээг олгох шаардлагагүй, дээрхи хугацаанаас өмнө олгож болно.

-Би Өвлөх эрхийн гэрчилгээ авчихлаа. Одоо яах вэ?

-Та орон сууц өмчлөгчөөр баталгаажихын тулд үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхээ улсын бүртгэлд бүртгүүлж “Гэрчилгээ” авна.

Орон сууцыг өмчлөх эрхийн “Гэрчилгээ” авснаар Та орон сууцны хууль ёсны өмчлөгч нь болно.

-Орон сууцыг өмчлөлдөө авснаар үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөх үү?

-Та орон сууцыг өмчлөлдөө авснаар үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөхгүй учир нь “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь хэсэгт орон сууцыг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас чөлөөлөхөөр заасан байна. /”Төрийн мэдээлэл” сэтгүүл, 2000 он, № 45/


Ихэнх оронд өв залгамжлал, бэлэглэлийн албан татварын тухай бие даасан хууль байдаг. Манай улсад ийм бие даасан хууль байхгүй бөгөөд өв залгамжлалаар хүлээн авч буй орон сууц нь тухайн иргэний орлого болж байгаа тул Хүн амын орлогын албан татварын хууль үйлчилнэ.

Хүн амын орлогын албан татварын хуулийн 4 дүгээр зүйлийн 9-д заасан “Энэ хуульд татвараас чөлөөлөхөөр зааснаас бусад орлого” гэдэгт хамаарч, уг хуулийн 7 дугаар зүйлийн 1 /13 дахь сэдвээр харуулсан хүснэгт/-д заасан хэмжээгээр албан татвар төлнө. Өөрөөр хэлбэл, өв залгамжлалаар авсан орон сууцны үнэ нь өв залгамжлагчийн тухайн жилийн орлого, татварын бүртгэлд бичигдэн зохих татвар төлөгдсөн байх учиртай.

## 21 .Орон сууц, хашаа, байшинтай хүн үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөх үү?

Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч иргэн, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага нь үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч байна.

**Үл хөдлөх эд хөрөнгөнд:** газар, газраас салгамагц зориулалт эдийн засгийн агуулгаа алдах олон наст ургамал, тарьц суулгац болон газраас салган хэрэглэж үл болох барилга, байгууламж, орон сууцны байшин зэрэг эд хөрөнгө багтана.



### Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг:

- түүний улсын бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр,
- үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй бол
- хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээр, хөрөнгийн даатгалд даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр тус тус тодорхойлно.

### Дараахь үл хөдлөх эд хөрөнгийг албан татвараас чөлөөлнө:



төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгө (төрийн болон боловсролын байгууллага, соёл, урлаг, эмнэлэг, эмнэлгийн үйлчилгээний байгууллага, хууль сахиулах болон батлан хамгаалах байгууллага зэрэг төсвөөс санхүүждэг бүх байгууллагын хөрөнгө хамаарна)



орон сууц (хүн суурьшин амьдрах зориулалттай, орон сууцны зориулалтаар нь ашиглаж байгаа бүх төрлийн орон сууц хамаарна)




Нийтийн эзэмшлийн барилгабайгууламж (нийтийн эзэмшил бүхий цахилгаан, дулаан, холбооны шугам сүлжээ, зүний худаг, узель, дэд станц, цэвэр, бохир усны газар доогуурх ус зайлуулах хоолой, гүүр, үерийн усны далан, цэвэрлэх байгууламж, зам талбай, гэрэлтүүлэг, инженерийн зориулалт бүхий худаг г.м хамаарна)

Эдгээрээс гадна *Монгол Улсад суугаа гадаад орнуудын дипломат байгууллагууд* (ЭСЯ, консулын газар)-ын *үйл ажиллагаанд хамааралгүй, хувийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгөөс бусад* үл хөдлөх эд хөрөнгө нь 1961 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Олон улсын Венийн Конвенцид зааснаар албан татвараас чөлөөлөгдөнө.

*Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг* татвар төлөгчийн өмчилж байгаа үл хөдлөх эд хөрөнгийн тухайн жилийн 1 дүгээр сарын 15-ны байдлаарх нийт дүнгээс татвараас чөлөөлөгдөхөөр заасан үл хөдлөх эд хөрөнгийн дүнг хассан ялгавраас **0.6 хувиар** тооцож, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулна.

**Орон сууц-** гэж хүн оршин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэрийг хэлнэ.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулинд *албан татвараас чөлөөлөгдөхөөр заасан үл хөдлөх эд хөрөнгөд орон сууц (нийтийн болон амины, төрийн болон тухайн нэг байгууллагын өмчид хамаарагдах нийтийн орон сууц, хоршооллын хувьчлагдсан орон сууц гэх мэт орон сууцны зориулалтаар ашиглагдаж байгаа бүх төрлийн орон сууц)* хамаарч байгааг Та анзаарсан буйзаа. Гэр хорооллын хашаа, байшин ч мөн энэ заалтад хамаарах учир үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас чөлөөлөгдөнө.



Харин орон сууцны барилгыг бусад зориулалтаар тухайлбал, дэлгүүр, кафе, цайны газар, эмийн сан, интернет кафе мэт төрөл бүрийн үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр ашиглаж байгаа бол үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас **чөлөөлөхгүй**.


Түүнчлэн орон сууцны зориулалттай байшин барилгын нэг хэсэгт үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж, нөгөө хэсэгт нь хүн амьдран суудаг бол **тухайн барилга байшингийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа хэсэгт** үл хөдлөх хөрөнгийн албан татвар ногдуулан тооцно.

Жишээ нь: Иргэн Д.Наран үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ бүхий 100 м<sup>2</sup> талбай бүхий 60 сая төгрөгийн үнэлгээтэй орон сууцтай. Уг сууцны 60 м<sup>2</sup> талбайг үйлчилгээ явуулахад, үлдсэн талбайг амьдран суух зориулалтаар ашигладаг ажээ. Энэ тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгийн нийт үнийн дүн (60 сая төгрөг)-гээс албан татвараас чөлөөлөгдөх талбайн үнийн дүн (24 сая төгрөг)-г хасаж, үлдэх 36 сая төгрөгнөөс 0.6 хувийн үл хөдлөх хөрөнгийн албан татварыг тооцно.

Татвар төлөгч үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг өөрийн өмчлөлд байгаа үл хөдлөх эд хөрөнгийн 1 дүгээр сарын 15-ны байдлаарх үнэлгээгээр тооцон хуулийн этгээдийн хувьд улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор тэнцүү хэмжээгээр, хувь хүний хувьд, жилд нэг удаа, жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор төсөвт төлөх үүрэгтэй.

Жишээ нь: Иргэн Л.Болдхуяг 2004 оны 1 дүгээр сарын 15-ны байдлаар 30 сая төгрөгийн үйлдвэрийн барилга, 10 сая төгрөгийн машины гаражтай гэж бүртгэгдсэн тул 2004 оны төлбөл зохих үл хөдлөх эд хөрөнгийн татвар нь  $(30 \text{ сая төг} + 10 \text{ сая төг}) * 0.6\% = 0.24 \text{ сая}$  буюу 240 мян.төгрөгийг 2004 оны 2 дугаар сарын 15-ны дотор төлсөн байх ёстой.


Үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгч өөрөө ашигладаггүй, бусдад түрээсээр эзэмшүүлдэг бол үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг өмчлөгч өөрөө төлнө.



Жишээ нь: Иргэн Д.Цагаан өөрийн өмчлөлийн 60 м<sup>2</sup> талбай бүхий, 90 сая төгрөгийн орон сууцыг иргэн Д.Насанд цайны газар, саун, үсчин ажиллуулах зориулалтаар түрээсээр эзэмшүүлж байгаа бол уг барилгад ногдох 540.0 мян.төгрөг  $(90 \text{ сая төг} * 0.6)$  -ийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг иргэн Д. Цагаан төлөх юм.

## 22. Хувийн машин ба татвар

Та хувийн машин авмагц яах ёстой вэ?



Тээврийн хэрэгслээ өмчилж авснаас хойш 72 цагийн дотор Замын цагдаагийн албанд бүртгүүлж оршин суугаа нутаг дэвсгэрийн татварын албанд автомашины татвар төлөх үүрэг хүлээнэ.


Автомашин ба өөрөө явагч хэрэгслийг өмчлөгч нь татвар төлөгч байна

- Аж ахуйн нэгж
- Байгууллага
- Хуулийн этгээд


• Иргэн

Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг жилийн 4 улиралд тэнцүү хэмжээгээр улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор төсөвт төлнө.


Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг жилд нэг удаа тухайн жилийн 6-р сарын 1-ний дотор төлнө.



Бүх төрлийн ачааны автомашин




Бүх төрлийн суудлын автомашин




Бүх төрлийн автобус




Мотоцикл



Тусгай зориулалтын автомашин /кран, засвар үйлчилгээний болон лабораторийн зориулалттай тоноглогдсон машин/



Трактор өөрөө явагч бусад хэрэгсэл /үр тарианы комбайн, гинжит трактор хамаардаггүй/



Авто чиргүүл

**Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварын хэмжээг:**

- **Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл**
- **Тодорхой тогтоосон орон нутагт** гэсэн 2 үзүүлэлтийг харгалзан хатуу тогтоодог. / Нийслэл хот, Дархан-Уул, Орхон аймгийн төв, бусад сумд/

**АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ**

Татвар ногдуулах Автомашинны төрөл	Жилд ногдуулах албан татвар/төг/	
	Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгийн төвд	Бусад бүх сумд
2 дугуйтай мотоцикль	2000	1800
3 дугуйтай мотоцикль	3000	2800
Суудлын машин /цилиндрийн багтаамж нэг тутамд төгрөгөөр/	2000 см хүртэл	16
	2001-3000 см хүртэл	18
	3001см-аас дээш	22
Микро автобус 15 хүртэл суудалтай	35000	28000
Автобус	52000	40000
Ачааны машин 1тн хүртэл даацтай	25000	20000
1-2 тн хүртэл даацтай	35000	28000
2-3 тн хүртэл даацтай	45000	36000
3-5 тн хүртэл даацтай	55000	44000
5-8 тн хүртэл даацтай	80000	80000
8-10 тн хүртэл	90000	72000
10 тн ! оос дээш даацтай	100000	80000
Тусгай зориулалтын машин	16000	15000
Трактор, өөрөө явагч бусад хэрэгсэл	14000	11200
Бага оврын трактор	7000	5600
Чиргүүл / даацын нэг тн тутамд/	5500	5500



## Таны машин ашиглалтаас гарвал та яах ёстой вэ?



Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл ашиглалтаас хасагдсан тохиолдолд өмчлөгч нь 1 сарын дотор улсын бүртгэлээс албан ёсоор хасуулж, түүнд ногдох албан татвараас дараа улирлаас эхлэн чөлөөлөгдөнө.

### Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварт заасан Замын хөдөлгөөн зохицуулах байгууллагын үүрэг:

- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл өмчлөгчийн тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд албан татвараа төлсөн тодорхойлолтыг үндэслэн шилжилт хөдөлгөөн хийх
- Тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний мэдээг улирал тутам гаргаж өгч байх
- Авто тээврийн хэрэгслийн албан татвар хураах, үзлэг явуулах, хяналт шалгалт хийх ажлыг татварын албатай хамтран гүйцэтгэх.

### Татвараас чөлөөлөгдөх авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд:

- Гадаадын дилломат төлөөлөгчийн газрын тээврийн хэрэгсэл
- Олон улсын байгууллагын тээврийн хэрэгсэл
- Аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа үр тарианы комбайн, гинжит трактор хамаардаг.

## 23. Бууны албан татварт хэдийг төлөх вэ?

Бууны албан татварт хэдэн төгрөг төлөх тухай асуудлыг мэдэхийн өмнө татвар төлөгч хэн байх вэ? гэдгийг авч үзье.



Бууны албан татвар төлөгч нь


## Бууны албан татвар төлөгчийн үүрэг

- Тухайн жилийн 12 дугаар сард цагдаагийн байгууллагад буут бүртгүүлнэ.
- Буу эвдэрч ашиглагдахгүй болсон тохиолдолд цагдаагийн байгууллагаар дүгнэлт гаргуулж “үнэмлэх” авч бүртгэлээс хасуулна

Бууг:

- Өвлөх
  - Худалдан авах
  - Бэлэг дурсгалд авах
- зэргээр эзэмшилдээ авбал цагдаагийн байгууллагад 30 хоногт багтаан бүртгүүлнэ.
- Буу эзэмшигч оршин суугаа газраасаа шилжвэл бүртгэлээс хасуулж, шилжин очсон нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад 30 хоногт бүртгүүлнэ.

**Бууг хоёр төрөл болгон ангилж албан татвар ногдуулдаг.**



## Бууны албан татварт жилд төлөх хэмжээ нь,

- Үрлэн сумтай буунд 4000 төгрөг
- 6,4 мм хүртэлх калибрийн бүх төрлийн буунд 4000 төгрөг
- 6,5 ба түүнээс дээш мм-ийн бүх төрлийн буунд 6000 төгрөг



Татвар төлөгч иргэн сум, дүүргийн татварын албанд бууны албан татвараас чөлөөлүүлэх хүсэлтээ бичгээр гаргаж хөдөлмөрийн чадваргүй, албан татвар төлөх орлогогүй гэдгээ баримтаар нотолно.

Мөн дараахь үндэслэлээр бууны албан татвараас чөлөөлж болно.



## Та татвараа төлөөгүй бол ямар хариуцлага хүлээх вэ?

“Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих татвар хураах тухай хууль”-ийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар татварыг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд татвар төлөхөөр хуульд заасан өдрөөс татвар төлсөн өдрийг хүргэлх хугацаанд хүү ногдуулна.

Хүүгийн хэмжээ нь “Татварын Ерөнхий хууль”-ийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар хоног тутамд 0,5 хувь байна.

## 24.Захиргааны шүүх ба татвар

Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэрийг хүлээн авч, хянан шийдвэрлэдэг Захиргааны хэргийн шүүх байгуулах ажил 2004 оны 6 дугаар сарын 1 гэхэд жигдэрсэн билээ. Улсын Их Хурал 2002 оны 12 дугаар сарын 26 –нд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль баталсан нь иргэд, хуулийн этгээдийн хувьд зөрчигдсөн эрхээ шинэ, мэргэжлийн шүүхээр хамгаалуулж, хүний эрхийг баталгаатай хангах нэг чухал алхам болсон юм.

**Захиргааны хэргийн шүүх нь** нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага, засгийн газрын бус зарим байгууллага, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг сургууль, эмнэлэг, холбоо харилцаа, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны болон шашны байгууллага, эдгээр байгууллагын нийтийн эрх зүйн хүрээнд захирамжлах, зохион байгуулах бүрэн эрхийг бие даан хэрэгжүүлдэг албан тушаалтнаас гаргасан захиргааны хууль бус актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэдэг.



## **Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлүүлэх**

Захиргааны байгууллага албан тушаалтны хууль бус акт нь таны хууль ёсны эрх ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тухайн байгууллага албан тушаалтны шууд харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргана.

Энэ нь аймаг, нийслэлийн татварын албаны татварын улсын байцаагчийн актыг зөвшөөрөхгүй байгаа бол тухайн аймаг, нийслэлийн, харин Үндэсний татварын ерөнхий газрын татварын улсын байцаагчийн актыг зөвшөөрөхгүй байгаа бол ҮТЕГ-ын дэргэдэх маргаан таслах зөвлөлд хандана гэсэн үг юм.

Таны гомдлыг хүлээн авсан өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хариу өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд энэ хугацааг байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор сунгаж хугацаа сунгасан тухай танд мэдэгдэх ёстой.

### **Таны гомдлыг хянаж үзээд дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана**

- Захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх
- Захиргааны актыг бүхэлд нь эсвэл холбогдох хэсгийг хүчингүй болгох
- Тухайн байгууллага, албан тушаалтанд захиргааны зохих акт /хуульд нийцсэн/ гаргахыг даалгах

Энэ шийдвэр нь заавал биелэгдэх шинжтэй буюу холбогдох байгууллага албан тушаалтан заавал биелүүлнэ.

Та гомдлоо дараахь хэлбэрээр гаргаж болно:

- Гомдлыг албан ёсны хэлээр бичгээр, амаар, телевизээр явуулж буй шууд нэвтрүүлгээр, тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан гаргаж болно.

### **Гомдолд тавигдах шаардлага:**

- Бичгээр гаргасан гомдолд овог нэр, оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсэг зурна. Гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зурж болно.
- Гомдлыг хамтран гаргасан бол бүгд гарын үсэг зурна. Тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурвал төлөөлөх эрхээ нотлох баримтыг хавсаргана. Энд дурдсанаас өөр зүйл шаардахыг хориглодог.



Дараахь тохиолдолд иргэн, хуулийн этгээд нь Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй:

- Хуульд тусгайлан заасан
- Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл
- Шууд харьяалах дээд шатны байгууллага албан тушаалтанд гаргасан гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлээгүй
- Харьяалах дээд шатны байгууллага албан тушаалтан байхгүй бол/30 хоногийн дотор/ нэхэмжлэлийг шууд захиргааны хэргийн шүүхэд гаргаж болно.

Та нэхэмжлэлээ тухайн шийдвэр гаргасан татварын маргаан таслах зөвлөлийн оршин байгаа газрын захиргааны шүүхэд гаргана. Өөрөөр хэлбэл, Улаанбаатарт бол нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд, хөдөө орон нутагт бол аймгийн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэлээ гаргана.

## Нэхэмжлэлдээ юу бичих вэ?

1. Нэхэмжлэлийг гаргаж байгаа захиргааны хэргийн шүүхийн нэр
2. Нэхэмжлэгч, хариуцагчийн овог, эцгийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, оршин байгаа газрын хаяг
3. Нэхэмжлэлийн шаардлагын агуулга гэдэгт:
  - Татварын алба, албан тушаалтан, улсын байцаагчийн гаргасан захиргааны акт нь таны эрх ашиг хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэдгийг нотолж, тухайн актыг хүчингүй болгуулах
  - Захиргааны акт илт хууль бус гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх
  - Нэхэмжлэгчийн хууль ёсны ямар эрх, ашиг сонирхлыг зөрчсөн болон түүнээс үүдэн гарах хохирлын тухай
  - Татварын алба, албан тушаалтны хууль бус үйлдэл, эс үйлдэхүй нэхэмжлэгчийн эрхийг хэрхэн зөрчсөн, түүний үр дагаврыг арилгах тухай зааж, зөрчигдсөн эрхээ хэрхэн сэргээлгэхийг хүсэж байгаа тухайгаа бичнэ.
4. Хавсаргасан баримт бичгийн жагсаалт.

Урьд нь татварын маргаантай хэргийг иргэний хэргийн нэгэн адил шүүх хянан хэлэлцэж, талууд тавьж байгаа шаардлага, татгалзлаа өөрөө нотлох үүрэг хүлээдэг байсан бол захиргааны хэргийн хувьд шүүх нотлох баримт цуглуулах үүрэгтэй болж байгаагаараа иргэн, хуулийн этгээдийн эрх илүү хамгаалагдах нөхцөл бүрдэж байна.

**ШИНЭ ШҮҮХ ТАНЫ ТӨЛӨӨ !**



## 25. Татвар төлөхгүй бол яах вэ?

Татвараа төлөөгүйн төлөө хүлээх хариуцлагыг хуулиар тодорхойлсон байдаг. Ямар тохиолдолд хэрхэн хариуцлага хүлээдэг болон татвараас зугтсанаараа татвар төлөгч юу алдаж болохыг авч үзье.

### Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйл. Татвар төлөгчид хүлээлгэх хариуцлага

1.Татвар ногдох орлогоо нуусан буюу санаатайгаар бууруулсан бол нуусан буюу бууруулсан орлогын татвар ногдуулах орлоготой тэнцэх хэмжээний торгууль ногдуулна

2.Орлогоос бусад татвар ногдох зүйлийг нуусан буюу түүний тоо хэмжээг санаатайгаар бууруулсан бол ногдох татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлсэн татвартай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна.

3.Татвар ногдох зүйлийн тоо, хэмжээг болгоомжгүйгээр бууруулсан бол ногдох татварыг нөхөн төлүүлж, саатуулсан хоног тутам нөхөн төлүүлсэн татварын дүнгээс бодож нэг хувийн хүү ногдуулна. Хүүгийн хэмжээ төлбөл зохих татварын 50 хувиас хэтэрч болохгүй.



Бид хуулиа мэдэж дагаж мөрдөх ёстой. Иргэн Ц орлого олсон бол татвараа төлнө гэдгээ мэдэж байх ёстой. Хууль мэдэхгүй байна гэдэг нь хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй. Энэ тохиолдолд Ц бол татвар ногдох орлогоо санаатайгаар нуусан байх тул тэрээр нуусан орлого болох 200,0 мянган төгрөгийн орлогын татвар ногдох орлоготой тэнцэх хэмжээний буюу жишээ нь, орон сууцаа бусдад түрээслүүлэхтэй холбогдуулан засвар, үйлчилгээ хийлгэх зэргээр 50,0 мянган төгрөг зарцуулсан байвал түүнийг хассан зөрүү болох 150,0 мянган төгрөгийн торгууль хүлээнэ. Хэрэв Ц шударгаар хандаж, 200,0 мянган төгрөгийн орлогоо мэдүүлсэн бол тэрээр 150,0 мянган төгрөгнөөсөө дунджаар бодоход 15,0 мянган төгрөг л төлөх ёстой.

Гэтэл орлогоо нууснаараа даруй 135,0 мянган төгрөгийн алдагдалд орж байна. Түүнээс гадна хүний нэр төр гэдэг хэмжихийн ч аргагүй үнэ цэнтэй. Татвараа нууж торгуулсан гэнэ лээ гэж нэрээ дуудуулах нь тийм ч таатай хэрэг биш гэдэг нь ойлгомжтой.



Орлогоос бусад /жишээ нь, татвар ногдох эд хөрөнгө/ татвар ногдох зүйлийг нуусан бол түүнд ногдох татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлсэн татвартай тэнцэх хэмжээний торгууль ногдуулдаг. А нь Улаанбаатар хотын оршин суугч бөгөөд микроавтобус нь 15 хүртэл хүний суудалтай бол жилд 35,0 мянган төгрөгийн албан татвар төлөх ёстой. 2 жил төлөөгүй учир төлбөл зохих татвар болох 70,0 мянга нөхөн төлж дээр нь торгуульд нэмж 70,0 мянга, нийт 140,0 мянгыг төлж хариуцлага хүлээх болно. Энэ хүн татвараа төлөөгүйгээс болоод даруй 70,0 мянган төгрөгийн алдагдалд орж байна гэсэн үг.

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт татвараас зайлсхийх санаатай үйлдлүүдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон байна. Татвар ногдох орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийг нуусан гэдэгт уг орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийг биетээр нуун дарагдуулах, үндэслэлгүйгээр бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд шилжүүлэх, нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайланд тусгахгүй орхигдуулах, нягтлан бодох бүртгэлд санаатайгаар буруу бичилт хийх, хууль бус хэлцэл хийж хууран мэхлэх, холбогдох баримт бичгийг гаргаж өгөхгүй байх, түүнчлэн баримт бичгийг татвар төлөхгүйн тулд хуурамчаар үйлдэх зэрэг үйлдэл, эх үйлдэхүйг ойлгодог. Мөн “санаатайгаар бууруулсан” гэдэгт татвар ногдох орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийн тоо хэмжээг нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, тайлан мэдээ, татвар тодорхойлох хуудсанд санаатай багасган тусгах, орлогоо багасгаж харуулахын тулд засварлах замаар хуурамч баримт бичиг үйлдэх, зардлаа хуурамчаар өсгөх буюу орлогоо зохиомлоор багасгах зэрэг үйлдлүүд хамаардаг байна.

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 3-т татвар ногдох зүйлийн тоо хэмжээг болгоомжгүйгээр бууруулахад хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон байна. Улсын дээд шүүхийн тайлбарт: “татвар ногдох зүйлийн тоо хэмжээг болгоомжгүйгээр бууруулах” гэдэгт татвар ногдох орлого, татвар ногдох зүйлийн тоо хэмжээг нягтлан бодох данс, бүртгэл, тайлан, иргэний орлого, татвар тодорхойлох хуудсанд тусгахдаа тооны үйлдэлд алдах, хуурамч буюу алдаатай тоог үндэслэх, тооцооны буюу бусад техник хэрэгслүүдийг буруу ашиглах, мэдлэг чадвар дутагдах, хайхрамжгүй хандах буюу зориудын бус бусад хэлбэрээр бууруулсныг ойлгоно гэж заасан байдаг.

### **Захиргааны хариуцлагын тухай хуулийн 44 дүгээр зүйл. Албан татварын тухай хууль тогтоомж зөрчих**

1. Албан татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаагүй, албан татварын мэдээ тайланг хугацаанд нь ирүүлээгүй, албан татварын хяналт хэрэгжүүлэхэд шаардлагатай баримт сэлт гаргаж өгөөгүй зэргээр албан татварын тухай хууль тогтоомж зөрчсөн бол 500-10000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Энэ зөрчлийг албан тушаалтан гаргасан бол 5000-30000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.



## Эрүүгийн хуулийн заалтууд

### **166 дугаар зүйл. Татвар төлөхөөс зайлсхийх**

166.1. Татвар ногдох их хэмжээний орлого, эд хөрөнгө, ажил, үйлчилгээ, бусад зүйлийг нуух, тэдгээрийн тоо хэмжээг зориуд бууруулан мэдээлэх, байнга оршин суугаа газар, хаягаа өөрчлөх зэргээр албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166.2. Энэ хэргийг давтан үйлдсэн, эсхүл онц их хэмжээний татвар ногдох орлого, эд хөрөнгө, ажил, үйлчилгээ, бусад зүйлийг нуусан бол эд хөрөнгийг хурааж, таваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Энд татвар ногдох орлого, эд хөрөнгө, ажил үйлчилгээ, бусад зүйлийг нуух үйлдэл нь Татварын ерөнхий хуульд заасантай ижил байдлаар тодорхойлогдох бөгөөд харин хэмжээ нь “их” болсноороо эрүүгийн хэрэг болж энэ хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээх болдог. Иймд хэдий хэмжээний зүйлийг нуухаар “их” гэж тооцогдох вэ гэдгийг авч үзье. Сүүлийн жилүүдэд хуульд ямар нэг торгуулийн ч юм уу мөнгөний хэмжээ тавихаас аль болох татгалзаж ямар нэг харьцуулах нэгжээр хэмжиж байх нь мөнгөний ханшны өөрчлөлтийн энэ үед илүү тохиромжтой гэж хууль тогтоогчид үзэх болсон нь зүйтэй юм. Тэгээд үндсэн нэгж нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ байхаар авч үзсэн. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг мөнгөний

ханш зэрэг тодорхой нөхцөл байдлыг харгалзан жил бүр Засгийн газраас тогтоодог бөгөөд 2004 оны 3 дугаар сарын 1-нээс эхлэн 40,0 мянган төгрөг байхаар тогтоосон байх жишээтэй. 2002 оны буюу одоо дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлд: нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 125-200 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээг их, 200-гаас дээш дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээг онц их хэмжээтэй гэж ойлгож байхаар тогтоосон байдаг. Иймд 5 -8 сая төгрөгийн /125\*40,0 мян=5 сая/ татвар ногдох орлого, эд хөрөнгө, ажил үйлчилгээ, бусад зүйлийг нуусан бол Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 200-250 дахин буюу 8-10 сая төгрөгөөр торгуулах эсвэл 3-6 сараар баривчлах, эсхүл 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлнэ гэсэн үг. Дээр нь шүүх хөрөнгийг нь хураах шийдвэр гаргах эрхтэй. Хэрэв 5 сая төгрөгнөөсөө татвараа төлсөн бол дунджаар 10 хувиар бодож 500,0 мянган төгрөгөө л төсөвт оруулах байсан. Гэтэл орлогоо нууснаараа 8-10 сая төгрөгөө торгуульд төлж эрүүгийн хариуцлага хүлээх нь татвар төлөгч өчүүхэн зүйлээс болж алдагдлаа хэд дахин нэмэгдүүлж болохыг төвөггүй харьцуулан харж болох байна. Хэрвээ 8 саяас дээш төгрөгийн татвар ногдох орлого, эд хөрөнгө, ажил үйлчилгээ, бусад зүйлийг нуусан бол Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар илүү хүнд ял ногдоно.

#### **167 дугаар зүйл. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль тогтоомж зөрчих**

167.1. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих хууль тогтоомжид заасан журмыг зөрчсөн, татварын хяналт шалгалтад саад учруулсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

Хэрэв татварын албаны шалгалтаас зугтаан шаардсан бичиг баримтыг нь гаргаж өгөхгүй байх, орон байрандаа байхгүй олон дахин явуулж чирэгдүүлэх зэргээр татварын хяналт шалгалтанд саад учруулсан бол Эрүүгийн хуулийн 167 дугаар зүйлд зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100-150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгуулах, буюу 3-6 сарын хугацаагаар баривчлах ял хүлээнэ гэдэг нь үүнээс харагдаж байна. Бас шүүх ийм ял ногдуулаад зогсохгүй татвар төлөгчийн хөрөнгийг нь хураах шийдвэр ч гаргаж болно.

Татвараа төлөхгүй бол хуульд заасан эдгээр хариуцлага хүлээх ёстой болох нь ээ. Иймд төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа, нийгэм эдийн засгийн зорилтуудыг хангах хөрөнгийн тогтвортой эх үүсвэрийг бий болгохын тулд бид татвараа цаг хугацаанд нь хуулийнх нь дагуу заавал төлөх үүрэгтэй.

## АСУУЛТ ХАРИУЛТ

**Асуулт 1:** Зуны 3 сард лагерт гардаг болохоор өөрийн 3 өрөө орон сууцаа бусдад хөлслүүлэх бодолтой байгаа юм. Энэ хугацаанд нийт хөлс нь 100,0 мян төгрөг байхаар тохирсон юм. Харин татвар төлдөг гэж сонссон. Ямар журмаар, хичнээн хэмжээний татвар төлөх талаар тайлбарлаж өгнө үү.

**Хариулт:** Хүн амын орлогын албан татварын хуулийн албан татвар ногдох орлогын талаар заасан 4 дүгээр зүйлийн 4.1.5-ын в-д “хөрөнгө түрээслүүлсний орлого, адилтгах бусад орлого” гэж заасан байгаа тул таны 3 сарын хугацаагаар орон сууцаа бусдад хөлслүүлээд авах эд хөрөнгө хөлсөлсний орлого бол хүн амын орлогын албан татвар ногдуулах зүйл мөн. Уг хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.в-д зааснаар хөрөнгө түрээслүүлснээс олсон нийт орлогоос хөрөнгө түрээслүүлсэнтэй холбогдон гарсан зардлыг хасч, татвар ногдох орлогыг тодорхойлно. Жишээ нь, та орон сууцаа хөлслүүлэхийн тулд гэрээгээ үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлэх, нотариатоор батлуулах зэрэгт 12000 төгрөг зарцуулсан гэж үзвэл таны татвар ногдох орлого 88000 төгрөг болно гэсэн үг. Одоо энэ 88000 төгрөгийн орлогоос ямар хэмжээгээр татвар төлөх ёстойг уг хуулийн 7 дугаар зүйлийн 1-д заасан байна. Өөрөөр хэлбэл, таны хөдөлмөрийн хөлс, адилтгах бусад орлого зэрэгтэй нэгтгэгдээд жилийн нийт татвар ногдох орлогын хэмжээ 2,4 сая хүрэхгүй байгаа бол 10 хувийн татвар төлнө. /13 дахь сэдэвт үзүүлсэн хүснэгтийг үзнэ үү/. Иймд та эд хөрөнгө хөлсөлсний хөлсөө авах үедээ 8800 төгрөгөө татварт тушааж, энэ тухайгаа Иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэртээ тэмдэглэл хийлгэж зохих албан ёсны баримтуудаа хадгалж байх нь танд хамгийн хялбар байх болно гэж зөвлөж байна. Гэхдээ хөрөнгө түрээслүүлсний орлогод ногдох албан татварыг дараа улирлын эхний сарын 15-ны дотор төлөх ёстой гэдгийг хуулийн 10 дугаар зүйлийн 10.70.3-т заасан байна. Жилийн эцэст Иргэний орлого, татвар тодорхойлох хуудсаар тайланг гаргахдаа энэ талаар тусган эцсийн тооцоо хийх нь зүйтэй.

**Асуулт 2:** Би орон сууц худалдан авах санаатай мөнгөө хуримтлуулж байгаа билээ. Гэтэл миний танил Д: “сууцаа худалдан авах болоогүй байгаа юм чинь надад 3 сая төгрөг 3 сарын хугацаагаар хүүтэй зээлдүүлээч, би Солонгос явж бараа татах гэтэл мөнгө багадаад байгаа. Найдвартай буцааж төлнө” гэж гуйгаад байна. Мөнгөө зээлдүүлэхэд татварын талаар би юу мэдэж хийх ёстой вэ?

**Хариулт:** Хүн амын орлогын албан татварын хуулийн албан татвар ногдох орлогын талаар заасан 4 дүгээр зүйлийн 4.1.5-ын д-д “зээлийн болон хадгаламжийн хүүгийн орлого, адилтгах бусад орлого” нь татвар ногдох зүйл мөн гэдгийг заасан бөгөөд мөн хуулийн 5.3.д-д зааснаар зээлийн хүүгийн орлогын дүнгээр татвар ногдох орлогыг тодорхойлно. Өөрөөр хэлбэл та 3 сая төгрөгөө сар бүрийн 5 хувийн хүүтэй зээлдүүлсэн бол сар бүрийн 150000 төгрөгийн хүү

авах ба үүнийг 3 сараар бодвол нийт 450000 төгрөгийн хүү авах ёстой. Татвар ногдох орлогыг энэ дүнгээр тодорхойлно. Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 4-т зааснаар зээлийн хүүгийн орлогод 15 хувийн татвар ногдуулахаар заасан байна. Өөрөөр хэлбэл та зээлийн хүүд авч байгаа 450000 төгрөгтөө 67500 төгрөгийн татвар төлөх үүрэгтэй. Харин уг хуулийн 12 дугаар зүйлийн 2-т хуулийн эдгээр заалтыг 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан байна. Иймд та өөрийн хүлээн авч байгаа зээлийн хүүдээ 2005 оны 1 дүгээр сарын 1 хүртэл хугацаанд татвар төлөхгүй юм байна.

Энэ явдал 2005 оны 1 дүгээр сараас хойш болсон бөгөөд Улсын Их Хурал Хүн амын орлогын албан татварын хуулийн 12 дугаар зүйлд өөрчлөлт оруулаагүй гэж бодъё. Ийм тохиолдолд та зээлийн хүүд ногдох 67500 төгрөгийн татвараа төлөх үүрэгтэй. Хүн амын орлогын албан татварын хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д зээлийн хүүг олгож байгаа байгууллага, иргэн хуульд заасан хувиар суутган авч, 3 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ гэж заасан байдаг. Ийнхүү татвар төлсөн тухай Иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр, Иргэний татвар тодорхойлох хуудсанд тусгах шаардлагагүй. Хэрэв татвараа төлөөгүй бол Татварын Ерөнхий хуулийн 13 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээх болно.

**Асуулт 3:** Би сумын төвд амьдардаг. Хүмүүст мөнгөөр ээмэг, бөгж, бугуйвч хийж өгч амжиргаагаа залгуулдаг юм. Сумын татварын улсын байцаагч намайг татвар төл гэдэг. Би үнэндээ хэдэн төгрөг, хаана, яаж төлөхөө мэдэхгүй л байна. Надад зөвлөгөө өгнө үү.

**Хариулт:** Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуульд зааснаар мөнгөний дарханы үйлчилгээ үзүүлж байгаа иргэн сар тутам нийслэлд 16000 төгрөг, Налайх, Багануур, Дархан-Уул, Орхон аймгийн аймгийн төвийн сумд болон байнгын ажиллагаатай боомттой сумдад 14000 төгрөг, бусад аймгийн төвийн сумдад 12000 төгрөг, бусад газарт 10000 төгрөгийн татвар төлөх үүрэгтэй. Та сар бүрийнхээ татварыг сумынхаа төсвийн дансанд тушаах ёстой.

**Асуулт 4:** Хөдөлмөрийн хөлс гэдэг бол ойлгомжтой байна. Хөдөлмөрийн гэрээнд заасан үндсэн цалинг хэлж байна гэж бодож байна. Харин түүнтэй адилтгах орлого гэдийг юу гэж ойлгох вэ?

**Хариулт:** Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого гэдэгт аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр үндсэн ажлын хэлбэрээр ажиллаж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал /байгууллагын ойгоор олгож байгаа шагнал г.м/ нэмэгдэл /цолны, ур чадварын г.м/, тэтгэмж /хөдөлмөрийн чадвараа түр алдсаны г.м/, адилтгах бусад орлого /томилолтын мөнгө, байр, унаа, хоолны мөнгө / зэргийг ойлгоно.



**Асуулт 5:** Нэгэн компанийн ажилтан Батаа тухайн жилд хөдөлмөрийн хөлсөнд 550.0 мян төг, улирлын ажлын үр дүнгээр 180.0 мян төг, болзолт уралдааны шагналд 90.0 мян төг, ур чадварын нэмэгдэл 70,0 мян төг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжид 10,0 мян төг, бусад орлого 10,0 мян төг авсан гэвэл Батаагийн татвар ногдох орлого нь хэд байх вэ?

**Хариулт:** Эдгээр орлогын нийлбэрээр Батаагийн тухайн жилийн татвар ногдох орлогыг тодорхойлно. Үүнд:  $550,0+180,0+90,0+70,0+10,0+10,0=910,0$  мян төгрөг байна.

**Асуулт 6:** Батаа одоо 910,0 мян төгрөгнөөс татвар төлөх үү?

**Хариулт:** Татвар ногдуулах орлогыг тодорхойлох талаар хуульд нарийвчлан заасан байдаг. Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг хассан зөрүүгээр татвар ногдуулах орлогыг тодорхойлно. Иймд Батаагийн татвар ногдох орлого 910,0 мян төгрөгнөөс түүний нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлд төлсөн 10%-ийг /тухайн үеийнхээр/ тооцож суутган түүний татвар ногдуулах орлогыг тодорхойлно.  $910,0-910,0*10\%=819,0$  мян төг болно.

**Асуулт 7:** Батаа 819,0 мян төгрөгнөөс хэдэн төгрөгийн татвар төлөх вэ?

**Хариулт:** Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт заасан шаталсан хэмжээгээр татвар ногдуулах хүснэгтээ ашиглана. Батаагийн жилийн орлого 2,4 сая-д хүрэхгүй байгаа тул 10%-аар тооцож, 81,9 мян төгрөгийн татвар ногдож байна.

**Асуулт 8:** Батаа 81,9 мян төгрөгийн татвар төлөх болж байна гэж ойлгож болох уу?

**Хариулт:** Татвараа төлөхийн өмнө ямар нэг хөнгөлөлт байгаа эсэхийг бас бодолцох хэрэгтэй. Хүн амын орлогын албан татварын хуулийн 9.3- т зааснаар жилийн 48,0 мян төгрөгийн татварыг хөнгөлдөг тул Батаа  $81,9-48,0=33,9$  мян төгрөгийн татвар төлнө.

**Асуулт 9:** Хувиараа бараа, материал, түүхий эд бэлтгэж борлуулсны орлого гэж юу вэ?

**Хариулт:** Иргэн бараа, материал, түүхий эдийг дотоод, гадаадын зах зээлээс олж бэлтгэн түүнийг иргэн, аж ахуй нэгж, байгууллагад худалдан борлуулж, бэлэн, бэлэн бусаар болон бараа солилцооны хэлбэрээр /биет зүйлээр/ олсон орлогыг хамааруулж ойлгодог. Жишээ нь: Иргэн Даваа 2,0 сая төгрөгийн барилгын материалыг Хятад улсаас худалдан авч, барилгын “Улаанбаатар” ХК-д 2,5 сая



төгрөгөөр худалдан борлуулсан гэвэл, татвар ногдох орлого нь 2,5 сая төг байна. Хуульд зааснаар энэ дүнгээс 3 %-аар бодож, Даваа 75,0 мян төгрөгийн татвар төлнө. Уг орлогыг Даваад олгож байгаа “Улаанбаатар” ХК-ийн нягтлан бодогч 75,0 мян төгрөгийг суутган авч төсөвт тушаах замаар хуулийн энэ заалт хэрэгждэг.

**Асуулт 10:** Хүн амын орлогын албан татварын хуулийн 4.1. 9-д “энэ хуульд албан татвараас чөлөөлөхөөр зааснаас бусад орлого” гэж заасныг тайлбарлана уу?

**Хариулт:** Монгол улсын Иргэний хуульд заасны дагуу шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас иргэнд нөхөн олгосон хөдөлмөрийн хөлс болон бусад орлого, хууль бусаар хорих ял шийтгүүлсний улмаас олгохыг зогсоосон тэтгэвэр, тэтгэмж, дарагдмал үнэт зүйл өмчилсний, алдуул мал болон гээгдэл хөрөнгийг эзэнд нь олж өгсний шагнал зэргийг хамааруулж ойлгодог.

**Асуулт 11:** Орлогыг гадаад валютаар буюу биет зүйлээр олж байгаа бол татвараа хэрхэн тооцдог вэ?

**Хариулт:** Гадаад валютаар олсон орлогыг Монгол банкнаас тогтоосон ханшаар төгрөгт шилжүүлэн тооцно. Биет хэлбэрээр олсон орлогыг тухайн нутаг дэвсгэрийн зах зээлийн дундаж үнээр тооцож үнэлнэ. Жишээ нь: Иргэн Дэлгэр хөдөлмөрийн хөлсөнд 100 ам. доллар, шагналд “Sony” маркийн телевизор авчээ. Тухайн өдрийн Монгол банкнаас тогтоосон төгрөгийн ам. доллартай харьцах ханш 1150 төг, телевизорын үнэ 250,0 мян төг байсан гэвэл татвар ногдох орлого нь  $/100 \cdot 1150 / + 250,0 = 365,0$  мян төг байна.

**Асуулт 12:** Иргэн Цэрэн эхнэр Хандын хамт түрээсийн гэрээгээр компанид мал малладаг. Гэрээнд заасны дагуу тэд мал малласны хөлсөнд бойжуулсан төлийн 70%-ийг авна. Тэд гэрээнийхээ дагуу 10 ишиг, 120 хурга, 5 тугал авсан. Цэрэн болон Ханд тус бүрийн татвар ногдох орлого хэд байх вэ?

**Хариулт:** Хуульд зааснаар гэр бүлээрээ буюу хамтарч гэрээгээр ажил үйлчилгээ гүйцэтгэсэн нөхцөлд иргэн тус бүрт ногдох орлогыг өөрсдийнх нь тодорхойлсноор, хэрэв ингэж тодорхойлох боломжгүй бол гэрээнд оролцогчдын тоонд хуваасан дүнгээр тодорхойлно. Хөдөлмөрийн хөлсөнд авч байгаа төлийг орон нутгийн зах зээлийн үнээр үнэлнэ. Бидний авсан жишээн дээр эдгээр төлийн зах зээлийн нийт үнэ нь 1520,0 мян төгрөг болсон гэж үзвэл татвар ногдуулах орлого нь иргэн Ханд, Цэрэн тус бүрт  $760,0$  мян төг  $/1520,0 : 2/$  төг байх болно. Хэрэв Цэрэн өөрийн орлогоо 700,0 мян, Ханд 820,0 мян гэж тодорхойлсон бол тэдний өөрсдийнх нь тодорхойлсноор албан

татвар ногдуулна.

**Асуулт 13:** Иргэн Онон хувцас оёж, сард 145,0 мян төгрөгийн орлого олсон. Энэхүү орлогыг олохдоо 60,0 мян төгрөгийн савхи, 1,0 мян төгрөгийн утас, 4,0 мян төгрөгийн цахилгаан товч худалдан авсан ба бүтээгдэхүүнээ дэлгүүрт тавьж заруулсны шимтгэлд 1,4 мян төгрөг төлжээ. Эдгээр нь бүгд баримтаар нотлогдож байна. Ононгийн татвар ногдох орлого хэд вэ?

**Хариулт:** Ажахуй эрхэлжолсон нийт орлогоос баримтаар нотлогдож байгаа зардал, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, онцгой албан татвар, байгалийн нөөц ашигласны хураамж, төлбөрийг хассан зөрүүгээр татвар ногдох орлогыг тодорхойлдог. Ононгийн нийт зардал нь  $60,0+1,0+4,0+1,4=66,4$  мян төг бөгөөд нийт орлого 145,0 мян төгрөгөөс хасвал 78,6 мян төгрөгийн татвар ногдуулах орлоготой байна.

**Асуулт 14:** Иргэн Донров хувиараа аж ахуй эрхэлж, барилга угсралтын ажил гүйцэтгэн, жилд 5000,0 мян төгрөгийн орлого олсон. Уг ажлыг гүйцэтгэхэд барилгын материал худалдан авахад 2000, 0 мян төг, цахилгаан сантехникийн материалын үнэ, холболтын ажлын хөлсөнд 500,0 мян төг, газар шорооны ажлыг гэр бүлийн гишүүдийн хүчээр хийсний хөлсөнд 200,0 мян төг, ажиллагсдын хөдөлмөрийн хөлсөнд 1600,0 мян төг, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлд 200,0 мян төг, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварт 130,0 мян төгрөгийн татвар төлсөн. Эдгээр бүх зардал баримтаар нотлогдож байгаа. Донровын татвар ногдуулах орлого хэд вэ?

**Хариулт:** Юуны өмнө Донровын баримтаар нотлогдож байгаа зардлын хэмжээг тодорхойлно.  $2000,0+500,0+1600,0+200,0+130,0=4630,0$  мян төг байна. Доноров гэр бүлийн гишүүддээ олгосон хөдөлмөрийн хөлс болох 200,0 мян төгрөгт эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй тул татвар ногдох орлогоос хасахгүй. Учир нь энэ тухай хуульд “Аж ахуй эрхлэгч нь өөрийн гэр бүлийн гишүүдэд хөдөлмөрийн хөлс олгож болох бөгөөд түүнийг зардалд тооцож татвар ногдох орлогоос хасах үндэслэл нь түүнд төлсөн нийгмийн даатгалын хэмжээ байна” гэж заасан. Иймд Донровын татвар ногдуулах орлого нь  $5000,0-4630,0=570,0$  мян төгрөг байна.

**Асуулт 15:** Иргэн Ганбат Өвөрхангай аймгийн Хархорин суманд шувууны аж ахуй эрхэлдэг. Ганбат 100 өндөглөгчтэй боловч жилийнхээ орлого, зарлагыг бүртгэж, тодорхойлж байгаагүй. Ганбатын орлогод хэрхэн татвар ногдуулах вэ?

**Хариулт:** Хүн амын орлогын албан татварын хуульд зааснаар албан татвар ногдуулах орлогоо тодорхойлоогүй буюу тодорхойлох боломжгүй бол албан татвар ногдуулах орлогыг байгаль, цаг уур, зах зээлийн нөхцөл ижил үйлдвэрлэгчтэй харьцуулсан жишгээр

татварын алба тодорхойлно. Татварын албаны судалгаагаар Өвөрхангай аймгийн Хархорин сумын шувууны аж ахуй эрхэлдэг иргэд нэг өндөглөгчөөс жилд дунджаар 5,0 мян төгрөгийн орлого олж, 3,5 мян төгрөгийн зардал гаргадаг нь тогтоогдсон байна. Иймд нэг өндөглөгчийн хувьд  $5,0 - 3,5 = 1,5$  мян төгрөгийн татвар ногдуулах орлоготой. Иймд энэ жишгээр бодож, Ганбатын шувууны аж ахуйн татвар ногдуулах орлого нь  $100 * 1,5 = 150,0$  мян төг байна.

**Асуулт 16:** Улсын баяр наадмын бөхийн барилдаанд түрүүлсэн иргэн улсаас 1000,0 мян төгрөгийн шагнал, ивээн тэтгэгч байгууллагуудаас 500 ам. долларын үнэтэй телевизор, 60,0 мян төгрөгийн үнэтэй монгол гутал, 80,0 мян төгрөгийн үнэтэй мөнгөн аягаар шагнуулсан бол түүний татвар ногдуулах орлого нь хэд байх вэ? Хэдэн төгрөгийн татвар төлөх вэ?

**Хариулт:** Тухайн үед 1 ам. долларын Монгол банкнаас зарласан ханш 1150 төг байсан гэж үзвэл түрүүлсэн бөхийн татвар ногдуулах орлого нь  $1000,0 + 500 * 1150 + 60,0 + 80,0 = 1715,0$  мян төг байна. Урлагийн тоглолт, биеийн тамир, спортын уралдаан тэмцээний шагналын орлогын дүнгээр татвар ногдуулах орлогыг тодорхойлох бөгөөд уг дүнгийн 10%-аар тооцож татвар ногдуулдаг тул түрүүлсэн бөхийн төлбөл зохих татварын хэмжээ 171,5 мян төг байна.

**Асуулт 17:** Иргэн Заяа үндсэн ажлын зэрэгцээгээр “Барс” ХК-д барилгын ажил хийж 3 дугаар сард 45,0 мян төгрөгийн орлого авсан байна. Тэгвэл “Барс” компани хэдэн төгрөг суутгах вэ?

**Хариулт:** Иргэн Заяа ажлынхаа хөлсөнд 3 дугаар сард авч байгаа 45,0 мян төгрөгөөс “Барс” компани  $4,5 / 45,0 * 10\%$  мян төгрөгийг суутган авч 4 дүгээр сарын 10-ны дотор төсөвт төлж, Заяагийн Иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэн баталгаажуулна.

**Асуулт 18:** Иргэн Цэнд орон сууцаа гадаадын иргэнд сар бүр 50,0 мян төгрөгөөр 1 жилийн хугацаагаар түрээслүүлжээ. Үүнээс сар бүр цахилгаан, дулааны зардалд 10,0 мян төгрөгийг төлдөг байв. Цэндийн татвар ногдуулах орлого хэд байх вэ?

**Хариулт:** Хүн амын орлогын албан татварын хуулийн 7.1-т зааснаар хөрөнгө түрээслүүлсний орлогод шаталсан хувь, хэмжээгээр татварыг ногдуулан дараа улирлын эхний сарын 15-ны дотор төсөвт төлж, Иргэний орлого, татвар тодорхойлох хуудсаар татварын тооцоо хийнэ. Өөрөөр хэлбэл, иргэн Цэнд  $48,0 ((50,0 * 12 - 10,0 * 12) * 10\% = 48,0)$  мян төгрөгийн татварыг ногдуулан төлөх бөгөөд төлсөн татварын талаар Иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт бичиж баталгаажуулан Иргэний орлого, татвар тодорхойлох хуудсаар жилийн татварын тооцоо хийнэ. Цэнд энэхүү түрээсийн төлбөрөөс өөр төрлийн татвар ногдох орлогогүй гэж үзвэл хуульд заасан 48,0

мян төгрөгийн хөнгөлөлтөө эдэлж, тэрээр татварын үүргээсээ бүрэн чөлөөлөгдөх тооцоо гарч байна.

**Асуулт 19:** “Ялалт” ХХК-ны ерөнхий захирал Бямбаа тодорхой хэмжээний мөнгөөр бооцоо тавьж тоглоод 100,0 мян төгрөгийн бооцоо авсан байна. Иргэн Бямбаа хэдэн төгрөгийн татвар төлөх вэ?

**Хариулт:** Бооцоо болон тааварт тоглоом, хонжворт сугалааны хонжворын орлогод татварыг 10%-аар тоохон суутгана. Тэгвэл бооцоот тоглоомыг зохион байгуулагч иргэн Бямбаагийн орлогоос  $10,0 / 100,0 * 10\%$  мян төгрөгийн татварыг ногдуулан суутган авч төсөвт төлнө.

**Асуулт-20:** Би өөрт байгаа хөрөнгөөрөө төрсөн сумынхаа төвд усан цахилгаан станц барих бодолтой байгаа юм. Тэгээд энэ үйл ажиллагааг явуулах хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах гэж байгаа. Хүү маань Германд байнга амьдардаг бөгөөд гэндээс усан цахилгаан станцын бүхий тоног төхөөрөмжийг оруулж ирэхэд тусалж чадна гээд байгаа. Иймд татварын талаар надад зөвөлж хэлэх зүйл байна уу?

**Хариулт:** Та ажлаа эхлэхийнхээ өмнө зөвлөгөө авах гэж байгаа чинь тун сайн хэрэг байна. Та шинээр компани байгуулахаасаа өмнө татварын хуулийн өөрт ашигтай байж болох зохицуулалтуудыг судалж, хууль зөрчихгүйгээр татварыг тойрох ямар боломж байна гэдгийг мэдэж ажлаа зөв эхлэх нь чухал. Хэрэв усан цахилгаан станц буюу компани байгуулахдаа гадаадын хөрөнгө оруулалттайгаар байгуулах юм бол татварын хэд хэдэн хөнгөлөлт эдлэх болно. Үүний тулд таны Германд байнга амьдран сууж байгаа хүү тань танай компанийн өөрийн хөрөнгийн 25-аас доошгүй хувийг оруулсан байхад уг компани бол гадаадын хөрөнгө оруулалттай компани гэж тооцогдоно. Гадаадын хөрөнгө оруулалттай компани нь эрчим хүчний буюу дэд бүтцийн салбарт байгуулагдаж байгаа тул татварын дараахь хөнгөлөлт эдэлнэ:

1. Гадаадаас дүрмийн сан буюу компанийн өөрийн хөрөнгийг бүрдүүлэхэд оруулж ирж байгаа тоног төхөөрөмж нь гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татваргүйгээр орж ирнэ.

2. Компани байгуулагдсанаас хойш 5 жилийн хугацаанд гадаадаас авч байгаа запас, сэлбэг хэрэгсэл, түүхий эд материалд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуудахгүй.

3. Байгуулагдсанаасаа хойшхи эхний 10 жилд компани чинь Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвараас бүрэн чөлөөлөгдөж, түүний дараагийн 5 жилд 50 хувийн хөнгөлөлт эдлэх болно.

Иймд би таныг хүүтэйгээ хамтран компаниа байгуулахыг зөвлөж байна. Хэрэв та ганцаараа энэ компанийг байгуулбал энэ бүх татварын хөнгөлөлтийг эдлэхгүй. Татварын хуулийг сайн судалснаараа ийнхүү хуулийн дагуу бөгөөд өөртөө ашигтай шийдвэр гаргаж болно гэдэг

нь үүнээс харагдаж байна. Энэ тухай Гадаадын хөрөнгө оруулалтын тухай, Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Гаалийн хуулиудын холбогдох зүйлүүдэд заасан байдаг.

**Асуулт-21:** Зарим ресторанд бидний захиалсан зүйлийн үнэ дээр нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/ 15 хувиар бодож нэмж авдаг байхад ихэнх газруудад шууд л захиалсан зүйлийнхээ үнийг төлүүлдэг. Энэ ямар учиртай байна вэ?

**Хариулт:** НӨАТ-ыг бараа борлуулж байгаа компаниуд буюу худалдагч-НӨАТ төлөгч худалдан авагчаас нэхэмжилж аваад дараа нь төсөвт төлөх үүрэгтэй байдаг. Иймд бидний захиалсан зүйлийн үнэ дээр нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/ 15 хувиар бодож нэмж авч байгаа ресторан бол хуулиа зохих ёсоор мөрдөж ажиллаж байгаа хэрэг. Харин зарим ресторан шууд л захиалсан зүйлийнхээ үнийг төлүүлж байгаа боловч тэд НӨАТ төлөгч хэвээрээ үлдэнэ. Өөрөөр хэлбэл биднээр шууд төлүүлээд байгаа үнэнд нь НӨАТ шингэчихсэн байгаа гэж ойлговол зохино. Хүмүүс анх харсан буюу сонссон үнэ дээр нь 15 хувийг нэмж авахад сэтгэлзүйн хувьд дарамтанд орж худалдагчид таагүй ханддаг тал байдгаас ийм аргыг өөрсдөө зохиосон хэрэг. Зүй нь жинхэнэ үнэ ба түүнд ногдох татвар нь тус тусдаа харагдаж байх юм бол худалдан авагчийн хувьд татвар төлөх соёл эзэмшиж, худалдагч байгууллагын хувьд татварын тооцоо нь ил тод харагдаж байх ач холбогдолтой юм.

**Асуулт-22:** Хүүгээ чанартай боловсрол эзэмшүүлэх зорилгоор нийслэлдээ хамгийн сайн гэгдэх нэгэн хувийн дунд сургуулийн нэгдүгээр ангид энэ жил оруулсан юм. Төлбөр нь эхнэр бид хоёрын 3 сарын орлоготой тэнцэхээр хэмжээтэй байгаа. Энд ямар нэг хөнгөлөлт байдаг болов уу?

**Хариулт:** Хүүхдийнхээ сургалтын төлбөрт төлсөн мөнгийг хүн амын орлогын албан татвар ногдох орлогоос хасч тооцон хөнгөлөлт эдлүүлэх талаар Хүн амын орлогын албан татварын хуульд заахдаа зөвхөн их, дээд болон тусгай мэргэжлийн сургуульд суралцагч хүүхдийн сургалтын төлбөрт л хамаатай байхаар заасан байна. Иймд ерөнхий боловсролын сургуульд суралцагчийн төлбөрт татварын энэ хөнгөлөлт хамаарахгүй гэж ойлгоно. Түүнчлэн дүүгийнхээ их сургуульд суралцах төлбөрийг төлсөн тохиолдолд энэ хөнгөлөлтийг эдлэх үү? гэсэн асуулт ч хааяа гардаг. “Монгол Улсын татварын тухай зарим хуулийн зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай” Улсын Дээд Шүүхийн 2002 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 100 дугаар тогтоолын 2,1,3-т: “Монгол Улсын Хүн амын орлогын албан татварын хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтын “их, дээд болон тусгай мэргэжлийн сургуульд суралцагч хүүхдийн сургалтын төлбөр” гэснийг татвар төлөгчийн төрсөн буюу үрчилж авсан хүүхдийн их, дээд болон тусгай мэргэжлийн сургуульд суралцагч нэг буюу хэд

хэдэн суралцагчийн сургалтанд төлсөн баримтаар нотлогдож байгаа төлбөрийн хэмжээг ойлгоно” гэж заасан байна. Иймд дүүгийнхээ төлбөрт төлсөн мөнгө хөнгөлөлтөд хамаарахгүй гэж ойлгох учиртай.

## НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

### А

**АЖАХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР-** ашгийн болон ашгийн бус хуулийн этгээдийн үйл ажиллагааны орлогод хуульд заасны дагуу ногдуулдаг орлогын албан татварын төрөл

**АЛБАН ТАТВАР-**Хууль тогтоомжийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлого, эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээнд тодорхой хугацаанд, тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгө

**АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР-**автомашин, өөрөө явагч хэрэгсэл өмчлөгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдийн хуульд заасны дагуу төлдөг хөрөнгийн татварын нэг төрөл

### Б

**БУУНЫ АЛБАН ТАТВАР-**буу эзэмшигч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдийн хуульд заасны дагуу төлдөг хөрөнгийн татварын нэг төрөл

### Г

**ГААЛИЙН ТАТВАР-** импортоор оруулж ирж байгаа бараанд ногдуулах албан татвар

**ГАДААДЫН ИРГЭН-** гадаад улсын харьяат иргэн болох нь албан ёсны баримтаар нотлогдож байгаа хувь хүн

**ГОМДОЛ-** Захиргааны байгууллага албан тушаалтны хууль бус акт нь таны хууль ёсны эрх ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тухайн байгууллага албан тушаалтны шууд харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан хүсэлт

**ГОМДОЛ ГАРГАХ ХЭЛБЭР-** Гомдлыг албан ёсны хэлээр бичгээр, амаар, телевизээр явуулж буй шууд нэвтрүүлгээр, тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан гаргаж болно

**ГОМДОЛ ТАВИХ ШААРДЛАГА-** бичгээр гаргасан гомдолд овог нэр, оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсэг зурна. Гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зурж болно. Гомдлыг хамтран гаргасан бол бүгд гарын үсэг зурна. Тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурвал төлөөлөх эрхээ нотлох баримтыг

хавсаргана. Энд дурдсанаас өөр зүйл шаардахыг хориглодог.

## Ж

**ЖИШГЭЭР ТАТВАР НОГДУУЛАХ** -албан татвар ногдуулах орлогоо тодорхойлоогүй буюу тодорхойлох боломжгүй бол албан татвар ногдуулах орлогыг байгаль, цаг уур, зах зээлийн нөхцөл, ижил үйлдвэрлэгчтэй харьцуулсан жишгээр татварын алба тодорхойлно

**ЖИШГЭЭР ТОДОРХОЙЛЖ ТАТВАР ТӨЛӨХ**-Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан тодорхой ажил үйлчилгээний орлогод хуульд заасан хэмжээний татварын урьдчилгаа төлж, иргэний татвар тодорхойлох хуудсаар татварын тайлан гаргах үед зөрүүг нь нөхөн төлүүлэх буюу эргүүлэн олгох арга

## З

**ЗАХИРГААНЫ ШҮҮХ**-нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага, засгийн газрын бус зарим байгууллага, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг сургууль, эмнэлэг, холбоо харилцаа, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны болон шашны байгууллага, эдгээр байгууллагын нийтийн эрх зүйн хүрээнд захирамжлах, зохион байгуулах бүрэн эрхийг бие даан хэрэгжүүлдэг албан тушаалтнаас гаргасан захиргааны хууль бус актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрх бүхий шүүх

## И

**“ИРГЭНИЙ ОРЛОГО, ТАТВАРЫН БҮРТГЭЛИЙН ДЭВТЭР”**- тухайн иргэн-татвар төлөгчийн авч буй нийт орлого, төлсөн татварыг тогтоосон загварын дагуу харуулсан анхан шатны бүртгэлийн дэвтэр

**“ИРГЭНИЙ ОРЛОГО, ТАТВАР ТОДОРХОЙЛОХ ХУУДАС”**- тухайн иргэн-татвар төлөгчийн татварын тайлан

## М

Монгол Улсын иргэн- Монгол Улсын Харьяатын тухай хуулийн дагуу тус улсын иргэн болох нь тодорхойлогдсон хувь хүн

## Н

**НИЙГМИЙН ДААТГАЛ**- иргэн буюу даатгуулагч болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид



заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТӨРӨЛ**-тэтгэврийн даатгал, тэтгэмжийн даатгал, эрүүл мэндийн даатгал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал, ажилгүйдлийн даатгал

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР**-иргэн хуулийн этгээдийн импортоор авсан болон экспортолсон бараа, Монгол улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэж борлуулсан болон импортолж борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд ноогдуулдаг шууд бус албан татварын нэг төрөл

**НЭХЭМЖЛЭЛ**-хуульд тусгайлан заасан, дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн, шууд харьяалах дээд шатны байгууллага албан тушаалтанд гаргасан гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлээгүй, харьяалах дээд шатны байгууллага албан тушаалтан байхгүй бол иргэн, хуулийн этгээд нь Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй

**НЭХЭМЖЛЭЛИЙН БҮРДҮҮЛБЭР**-Нэхэмжлэлд заавал тусгахаар хуульд заасан шаардлага. Үүнд: нэхэмжлэлийг гаргаж байгаа захиргааны хэргийн шүүхийн нэр, нэхэмжлэгч, хариуцагчийн овог, эцгийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, оршин байгаа газрын хаяг, нэхэмжлэлийн шаардлагын агуулга /татварын алба, албан тушаалтан, улсын байцаагчийн гаргасан захиргааны акт нь таны эрх ашиг хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэдгийг нотолж, тухайн актыг хүчингүй болгуулахаар, захиргааны акт илт хууль бус гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх, нэхэмжлэгчийн хууль ёсны ямар эрх, ашиг сонирхлыг зөрчсөн болон түүнээс үүдэн гарах хохирлын тухай, татварын алба, албан тушаалтаны хууль бус үйлдэл, эс үйлдэхүй нэхэмжлэгчийн эрхийг хэрхэн зөрчсөн, түүний үр дагаврыг арилгах тухай зааж, зөрчигдсөн эрхээ хэрхэн сэргээлгэхийг хүсэж байгаа тухай/, хавсаргасан баримт бичгийн жагсаалт

## О

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАР**-зарим төрлийн бүтээгдэхүүний хэрэглээг хязгаарлах, татварын адил тэгш, шударга байх зарчмыг хангах зорилгоор ногдуулах ба бүх төрлийн согтууруулах ундаа, бүх төрлийн тамхи, авто бензин, дизелийн түлш, суудлын автомашинд ногдуулна

**ОРЛОГЫГ НЬ ТУХАЙ БҮР ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ**-хуульд нэр заасан ажил, үйлчилгээ эрхэлж байгаа иргэний орлогод хуулиар тогтоосон хэмжээний татвар ногдуулах арга

## Т

**ТАТВАР-Хуульд заасны дагуу таны орлого, эд хөрөнгө зэрэгт ногдуулж, улс, орон нутгийн төсөвт оруулдаг мөнгөн хөрөнгө**

**ТАТВАР НОГДУУЛАХ ОРЛОГО-хуульд заасны дагуу татвар ногдуулахаар тодорхойлогдсон орлого. Жишээ нь, татвар төлөгчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг хассан дүнгээр татвар ногдуулах орлогыг тодорхойлно**

**ТАТВАР ТӨЛӨГЧ- Татвар ногдох орлого бүхий Монгол Улсын иргэн, Монгол улсад орлого олж байгаа оршин суугч бус этгээд, Монгол улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн**

**ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ОРЛОГО- хуульд заасны дагуу албан татварт хамрагдвал зохих татвар төлөгчийн орлого, жишээ нь, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого**

**ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ-татвар ногдуулах орлогоос хуульд заасан хэмжээгээр тооцох хувь буюу төлбөл зохих албан татварын хэмжээ, жишээ нь, татвар төлөгчийн жилийн татвар ногдуулах орлого нь 2,4 сая хүртэл байвал 10 хувиар тооцож хүн амын орлогын албан татвар ногдуулна гэх мэт**

**ТАТВАРЫН АЛБА- татвартай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын тогтолцоо**

**ТАТВАРЫН УЛСЫН БАЙЦААГЧ-Татварын албаны үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх үүрэг бүхий төрийн захиргааны жинхэнэ албан хаагч**

**ТӨЛБӨР- төрийн өмч /иргэдэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц зэрэг/-ийг ашиглуулсны төлөө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авч улс, орон нутгийн төсөв, тусгай зориулалтын санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө**

## Ү

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ-газар, газраас салгамагц зориулалт эдийн засгийн агуулгаа алдах олон наст ургамал, тарьц суулгац болон газраас салган хэрэглэж үл болох барилга, байгууламж, орон сууцны байшин зэрэг эд хөрөнгө**

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАР- Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч иргэн, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын тухайн үл хөдлөх эд хөрөнгөнд хөрөнгийн албан татварын нэг төрөл**

## Х

**ХАРЬАЛАЛГҮЙ ХҮН- аль ч улсын иргэн биш хувь хүн**

**ХУВИАРАА АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ**- өөрийн хувийн өмчдөө тулгуурлан аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж, ашиг орлогоо нэмэгдүүлж байгаа иргэн

**ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ**- хувьцаат буюу хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигч буюу хувь нийлүүлэгч нь Компанийн тухай хуульд заасан журмаар компанийн цэвэр ашгаас эзэмшиж байгаа хувьцааныхаа хэмжээтэй хувь тэнцүүлэн хуваарилуулан авч байгаа мөнгөн хөрөнгө

**ХУВЬ ХҮРТЭГЧИЙН ОРЛОГО**- компаниас бусад аж ахуйн нэгжийн цэвэр ашгаас хөрөнгө оруулагч оруулсан хөрөнгөтэй хувь тэнцүүлэн зохих журмын дагуу хуваарилуулан авч байгаа болон хамтран ажиллах гэрээний талууд хамтын үйл ажиллагааны үр дүнгээс гэрээнд заасны дагуу хуваарилуулан авч байгаа хөрөнгө

**ХУРААМЖ**-хууль тогтоомжийн дагуу төрийн зохих байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлсний төлөө тэднээс тухай бүр авч улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгө

**ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ**- үл хөдлөх эд хөрөнгөөс бусад биет хөрөнгө, жишээ нь, үйлдвэрийн зориулалттай тоног төхөөрөмж, машин, механизм, тээврийн хэрэгсэл г.м.

**ХҮҮГИЙН ОРЛОГО**-банк, зээлийн байгууллагаас авч байгаа хадгаламжийн хүүгээс гадна бусдад олгосон зээлийн хүү, өрийн бичиг зэрэг үнэт цаасны хүү

Э

**ЭРХИЙН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО**-зохиогчийн эрх, программ хангамж, патент, зураг төсөл, загвар, барааны тэмдэг, ноу-хау болон кино, видео бичлэг, аудиобичлэг, бусад төрлийн бичлэг ашигласны буюу ашиглах эрх эдэлсний төлбөр

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ**- иргэн буюу даатгуулагч болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу даатгалын хураамж төлж, даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, даатгуулагчийг эмчлүүлэхэд гарсан эмчилгээ, үйлчилгээний зардлын төлбөрийг уг сангаас төлөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ

## НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Үндсэн хууль, УБ., 1992 он
2. Татварын ерөнхий хууль
3. Иргэний хууль
4. Хүн амын орлогын албан татварын хууль
5. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хууль
6. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль
7. Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль
8. Онцгой албан татварын хууль
9. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хууль
10. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хууль
11. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль
12. Гаалийн хууль
13. Гаалийн тарифын тухай хууль
14. Төрийн албаны тухай хууль
15. Төрийн бус байгууллагын тухай хууль
16. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хууль
17. Бууны албан татварын тухай хууль
18. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
19. “Төрийн мэдээлэл” сэтгүүл 1992-2004 он
20. “Татвар төлөгч иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагад тусламж” 1, 2, 3, 4, 5 дахь дэвтэр, Монгол Улсын Үндэсний Татварын Ерөнхий газар, УБ., 2002 он
21. Д.Дүгэржав, М.Гомбосүрэн, “Татварын эрх зүй” УБ., 2003 он

ТАТВАРЫН АЛБАНЫ МЭДЭЭЛЛИЙН  
ТӨВҮҮДИЙН УТАС

**Нийслэлийн татварын газрын зөвлөгөө өгөх төвүүд**

1. Нийслэлийн татварын газар	328220
2. Баянгол дүүргийн татварын хэлтэс	363123
3. Баянзүрх дүүргийн татварын хэлтэс	460942
4. Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс	633223
5. Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс	322212
6. Хан-Уул дүүргийн татварын хэлтэс	345305
8. Багануур дүүргийн татварын хэлтэс	22987
9. Налайх дүүргийн татварын хэлтэс	22383

**Аймгуудын татварын албаны мэдээлэлийн  
төвийн утасны лавлах**

№	Аймгийн нэрс	Угтвар код	Бүсийн код	Холбооны утас	Харилцах утас
1	Архангай	01	33 -2	3111	2806
2	Баян-Өлгий	01	42 -2		2661
3	Баянхонгор	01	44-2	-	2249
4	Булган	01	34-2	-	22693
5	Говь-Алтай	01	48-2	-	3753
6	Говьсүмбэр	01	54-2	-	3263
7	Дархан-Уул	01	37-2	-	37346
8	Дорноговь	01	52-2	-	3976
9	Дорнод	01	58-2	-	1286
10	Дундговь	01	59-2	-	3628
11	Завхан	01	46-2	41147	2221
12	Орхон	01	35-2	-	22757
13	Өвөрхангай аймаг	01	32-2	-	22710
14	Өмнөговь	01	53-2	-	2464
15	Сүхбаатар	01	51-2	-	699
16	Сэлэнгэ	01	36-2	-	23930
17	Төв	01	27-2	-	3926
18	Увс	01	45 -2	-	3822
19	Ховд	01	43-2	-	2185
20	Хөвсгөл	01	38-2	-	4815
21	Хэнтий	01	56-2	-	2530

## Зарим шаардлагтай маягтууд

ҮТЕГ-ын даргын 200... оны  
6 дугаар сарын 28-ны өдрийн  
129 тоот тушаалын 2 дугаар хавсралт

Маягт ТТ – 06      ҮНДЭСНИЙ ТАТВАРЫН АЛБА

Иргэний орлого, татвар тодорхойлох хуудас

ТТД: \_\_\_\_\_

Зөвхөн татварын албаны

хэрэгцээнд

БТД: \_\_\_\_\_

Татварын байцаагч: \_\_\_\_\_

Тэмдэг

Хүлээн авсан сар өдөр \_\_\_\_\_

Нэр:-----

Тайлант хугацаа: он -----

/ мянган төгрөгөөр/

1. хөдөлмөрийн гэрээгээр үндсэн ажлын хэлбэрээр ажиллаж авсан  
----- цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй  
адилтгах орлого  
а/ НДШ болон ЭМД  
б/ Татвар ногдуулах орлого /1- 1а/
2. Гэрээгээр ажил үүрэг гүйцэтгэж олсон орлого
3. Хувиараа бараа, материал бэлтгэж борлуулсны орлого  
а/Бараа, материал бэлтгэхтэй холбогдон гаргасан баримтаар  
нотлогдох зардал  
б/ Татвар ногдуулах орлого /3- 3а /
4. Хөрөнгө түрээслүүлсний орлого  
а/ Хөрөнгө түрээслүүлсэнтэй холбогдон гарсан зардал  
б/ Татвар ногдуулах орлого /4- 4а /
5. Аж ахуй / бусад төрлийн / эрхэлсний орлого  
а/ Баримтаар нотлогдож буй хасагдах зардлууд:
  - Материалын зардал / түүхий эд, уур ус, эрчим хүч, түлш, сэлбэг,баглаа боодол г.м /
  - Түрээсийн төлбөр
  - Банкны зээлийн хүү
  - Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс
  - Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл

- Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл
  - Томилолтын зардал
  - Онцгой албан татвар
  - АТБӨЯХ-ийн татвар
  - Байгалийн нөөц ашигласны төлбөр
- б/ Татвар ногдуулах орлого /5 –5а /
6. Татвараас чөлөөлөх орлого /6а+ 6б+ 6в /
- а/ Аминдаа орон сууцны барилга барих, худалдан авахад зориулсан хөрөнгө
- б/ Мэргэжлийн сургуульд суралцагч хүүхдийн төлбөрийн жишиг дүн
- в/ Боловсролын сан, нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагад өргөсөн хандив
7. Татвар ногдуулах нийт орлогын дүн / 1б+2+3б+4б+5б++6 /
8. Ногдсон татвар / шаталсан хувиар/
9. Татварын хөнгөлөлт
- 10 Үр тариа, хүнсний ногооны үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулсан татварын 50%
- 11 Нийт төлбөл зохих татварын дүн / 8-9-10 /
- 12 Тайлангийн хугацаанд төлсөн татвар, бүгд / 12а+12б/
- а/ Тайлангийн хугацаанд төсөвт төлсөн татварын дүн
- б/ААНБ-д суутгуулсан татварын дүн
13. Урьд тайлангийн эцсийн илүү / - /, дутуу /+ /
14. Эцсийн тооцоогоор илүү / - /, дутуу / +/, / 13+11+12/

Орлого татвараа үнэн зөв тодорхойлсон

татвар төлөгч: /...../

ИОТГХ-ыг шалгасан

татварын байцаагч: /...../

200. . оны . . . . сарын . . . . өдөр

Жич: Тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах Татварын албанд ирүүлнэ.



## ҮНДЭСНИЙ ТАТВАРЫН АЛБА

### ТАТВАР ТӨЛӨГЧ ИРГЭНИЙ ОРЛОГО, ТАТВАРЫН БҮРТГЭЛИЙН ДЭВТЭР

200.. он

#### **Санамж:**

1. ААНБ-д хөдөлмөрийн гэрээгээр, үндсэн ажлын хэлбэрээр ажиллаж авсан орлогыг олгосон ААНБ-аар жилийн эцэст нийт дүнгээр нь нэг удаа бүртгүүлнэ. Харин оны дундуур өөр байгууллагад шилжин ажиллавал ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан үед бүртгүүлнэ.

2. Аж ахуй эрхэлсний орлогыг улирлаар нь гаргаж бөглөнө.

3. Гэрээгээр ажил үүрэг гүйцэтгэх, хувиараа бараа, материал түүхий эд бэлтгэж борлуулах хөрөнгө түрээслүүлэх хэлбэрээр олсон орлогыг олсон тухай бүрт орлого олгосон ААНБ, иргэнээр бөглүүлнэ.

ҮТЕГ –ын даргын 129 дүгээр тушаалын  
11 дүгээр хавсралтаар батлав.

## ТАТВАР ТӨЛӨГЧ ИРГЭНИЙ ОРЛОГО, ТАТВАРЫН БҮРТГЭЛИЙН ДЭВТЭР

----- Овог, нэр -----

/ Тамга /

/Гарын үсэг /

### Татварын албаны дарга

1. Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр үндсэн ажлын хэлбэрээр ажиллаж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, адилтгах бусад орлого

Дд	Орлого олгосон аж ахуйн нэгж, байгууллага	Тухайн жилд ажилласан хугацаа	Ажилласан хугацаанд олгосон орлогын нийт дүн	Суутгасан татвар	Гарын үсэг тэмдэг

2. Үндсэн ажлын газраас бусад аж ахуйн нэгж, байгууллага иргэдтэй байгуулсан гэрээгээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан цалин, хөлс, шагнал, адилтгах бусад орлого

№	Орлого олгосон аж ахуйн нэгж, байгууллага	Орлого олгосон огноо	Орлогын дүн	Суутгасан татвар	Гарын үсэг тэмдэг

### 3. Аж ахуй эрхэлсний орлого

Тайлант он, улирлын	Татвар ногдох орлого	ТНО-оос хасагдах зардал	Татвар ногдуулах орлого	Ногдсон татвар	Төлсөн татвар	Хянасан байцаагч		
						нэр	огноо	Гарын үсэг тэмдэг

### 4.Хувиараа бараа материал, түүхий эд бэлтгэж борлуулсны орлого

№	Худалдаж авсан аж ахуйн нэгж, байгууллага		Орлого олгосон огноо	Орлогын дүн	Суутгасан татвар	Гарын үсэг тэмдэг
	ТТД	Нэр				

### 5. Хөрөнгө түрээслүүлсний орлого

№	Хөрөнгө түрээсэлсэн аж ахуйн нэгж байгууллага, иргэн		Хөрөнгө түрээслүүлсний орлого	Хөрөнгө түрээслүүлэх тэй холбогдон гарсан зардал	Татвар ногдуулах орлого	Гарын үсэг тэмдэг
	ТТД	Нэр				

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИАС

**3 дугаар зүйл. Албан татвар төлөгч**

1. Монгол Улсын иргэн, Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн /цаашид “иргэн” гэх/, харъяалалгүй хүн, Монгол Улсад орлого олж байгаа Монгол Улсад оршин суугч бус этгээд албан татвар төлөгч байна.

2. Монгол Улсад татварын жилийн аль ч үед хэвийн ажиллах байртай, татварын жилд эхэлсэн буюу дууссан аливаа 12 сарын хугацаанд 183 хоног, түүнээс дээш хугацаагаар оршин сууж байгаа иргэн, харъяалалгүй хүн, гадаадад томилогдон сууж байгаа Монгол Улсын иргэнийг Монгол Улсад байнга оршин суугч татвар төлөгч гэнэ. Байнга оршин суугч татвар төлөгч нь Монгол Улсад болон гадаадад олсон орлогоосоо албан татвар төлнө.

3. Монгол Улсад 183 хоногоос доош хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэн болон харъяалалгүй хүнийг түр оршин суугч татвар төлөгч гэнэ.

4. Байнга болон түр оршин суугчаас бусад татвар төлөгчийг Монгол Улсад оршин суугч бус татвар төлөгч гэнэ. Түр оршин суугч болон оршин суугч бус татвар төлөгч нь Монгол Улсад олсон орлогоосоо албан татвар төлнө.

5. Үндэсний татварын алба татвар төлөгчийг дараах журмаар бүртгэнэ:

1/ байнга буюу түр оршин суугч татвар төлөгч нь тухайн нутаг дэвсгэрийнхээ татварын албанд бүртгүүлж, татвар төлөгчийн бүртгэлийн дугаар авна;

2/ татвар төлөгч нь татвар төлөгчийн бүртгэлийн дугаар авахдаа бүртгэлийн маягт авч бөглөнө;

3/ татварын алба нь татвар төлөгчийн дугаар бүхий гэрчилгээг татвар төлөгчид олгоно. Бүртгэлийн маягт, татвар төлөгчийн гэрчилгээний загварыг Үндэсний татварын ерөнхий газар батална;

4/ аж ахуйн нэгж, байгууллага нь иргэнд орлого олгох бүрдээ түүний татвар төлөгчийн дугаарыг орлого олгосон тухай баримтад тэмдэглэж, иргэн бүрт олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан татварын хэмжээг тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж мэдэгдэнэ. /Энэ зүйлийг 1997 оны 4 дүгээр сарын 17-ны хуулиар өөрчлөн найруулсан/.

#### **4 дүгээр зүйл. Албан татвар ногдох орлого**

1. Албан татвар төлөгчийн жилд олсон дараахь орлогод албан татвар ногдоно:

1/ цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого:

а/ аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр үндсэн ажлын хэлбэрээр ажиллаж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл тэтгэмж, адилтгах бусад орлого;

б/ үндсэн ажлын газраас бусад аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, адилтгах бусад орлого;

в/ тэтгэвэр, тэтгэврийн нэмэгдэл, тэтгэмж;

2/ Энэ заалтыг 1997 оны 4 дүгээр сарын 17-ны хуулиар хассан/.

3/ аж ахуй эрхэлсний орлого;

4/ хувиараа бараа, материал, түүхий эд бэлтгэж борлуулсны орлого;

5/ хөрөнгийн хөдлөл, эрхийн орлого:

а/ үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого, адилтгах бусад орлого;

б/ хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлого;

в/хөрөнгө түрээслүүлсний орлого, адилтгах бусад орлого;

г/ эрхийн шимтгэлийн орлого /зохиогчийн эрх, программ хангамж, патент, зураг төсөл, загвар, барааны тэмдэг, ноу-хау болон кино, видеобичлэг, аудиобичлэг, бусад төрлийн бичлэг ашигласны буюу ашиглах эрх эдэлсний төлбөр гэх мэт/;

д/ зээлийн болон хадгаламжийн хүүгийн орлого, адилтгах бусад орлого.

б/шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл зохиогч, шинэ бүтээл оновчтой санал гаргагч, загвар зохион бүтээгчийн шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого;

7/ урлагийн тоглолт, биеийн тамир, спортын уралдаан, тэмцээний шагнал;

8/ бооцоот болон тааварт тоглоом, хонжворт сугалааны хонжворын орлого

9/ энэ хуульд албан татвараас чөлөөлөхөөр зааснаас бусад орлого.

2. Албан татвар ногдох орлогод мөнгөн /үндэсний болон гадаад валютаар/ болон биет хэлбэрээр олсон зүйлийг оруулна. Биет хэлбэрээр олсон зүйлийг тухайн орон нутаг /аймаг, нийслэл/-ийн биржийн дундаж үнээр үнэлнэ. Гадаад валютаар олсон орлогыг

төгрөгт шилжүүлэхдээ уг валютыг банкинд худалдах тухайн өдрийн Монголбанкнаас тогтоосон ханшийг үндэслэнэ.

## **5 дугаар зүйл. Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох**

Албан татвар ногдуулах орлогыг дараахь байдлаар тодорхойлно:

1/ цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг:

а/ [энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн “а”](#)-д заасан орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр;

б/ [энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн “б”](#)-д заасан орлогын нийлбэр дүнгээр;

в/ тэтгэвэр, тэтгэврийн нэмэгдэл, тэтгэмжийн дүнгээр;

г/ гэр бүлээрээ буюу хамтарч гэрээгээр ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн нөхцөлд иргэн тус бүрт ногдох орлогыг өөрсдийнх нь тодорхойлсноор, хэрэв ингэж тодорхойлох боломжгүй бол гэрээнд оролцогчдын тоонд хуваасан дүнгээр;

2/ аж ахуй эрхлэгчийн орлогыг:

а/ /Энэ заалтыг 1997.4.17-ны өдрийн хуулиар хассан./

б/ аж ахуй эрхэлж олсон нийт орлогоос баримтаар нотлогдож буй зардал /түүхий эд, үндсэн болон туслах материал, хагас боловсруулсан зүйл, уур, ус, эрчим хүч, түлш, шатахуун, сэлбэг хэрэгсэл, сав, баглаа боодлын зардал, түрээсийн болон банкны зээлийн хүүгийн төлбөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, томилолтын зардал, эрүүл мэнд, нийгмийн даатгалын болон үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэл/, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, онцгой албан татвар, байгалийн нөөц ашигласны хураамж, төлбөрийг хассан зөрүүгээр.

Гэр бүлийн гишүүдэд олгосон хөдөлмөрийн хөлсийг нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн хэмжээтэй хувь тэнцүүлэн бодож зардалд тооцно.

Аж ахуй эрхлэгч нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнээс өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулсан байвал тэдгээрийг зардалд тооцохгүй;

в/ гахай, шувуу, туулай, зөгийн аж ахуй, тэдгээртэй адилтгах аж ахуй, газар тариалангийн болон хувиараа бусад үйлдвэрлэл эрхлэгч нь албан татвар ногдуулах орлогоо энэ зүйлийн 2-ын “б”-д заасны дагуу өөрөө тодорхойлно.

Албан татвар ногдуулах орлогоо тодорхойлоогүй буюу тодорхойлох боломжгүй бол албан татвар ногдуулах орлогыг байгаль, цаг уур, зах зээлийн нөхцөл, ижил үйлдвэрлэгчтэй харьцуулсан жишгээр татварын алба тодорхойлно.

3/ хөрөнгийн хөдлөл, эрхийн орлогыг:

а/ үл хөдлөх хөрөнгө худалдснаас олсон орлогын дүнгээр;

б/ 1997.4.17-ны хуулиар “б” заалтыг хассан./

в/ хөрөнгө түрээслүүлснээс олсон нийт орлогоос хөрөнгө түрээслүүлэхтэй холбогдон гарсан зардлыг хассан зөрүүгээр;

г/ хувьцааны ногдол ашгийн дүнгээр, хувь хүртэгчид ногдсон орлогын дүнгээр;

д/ зээлийн болон хадгаламжийн хүүгийн орлого, адилтгах бусад орлогын дүнгээр;

е/ эрхийн шимтгэлийн орлогын дүнгээр.

4/ хувиараа бараа, материал, түүхий эд бэлтгэж борлуулсны орлогыг нийт орлогоос баримтаар нотлогдож буй зардлыг хассан зөрүүгээр;

5/ шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл зохиогч, шинэ бүтээл, оновчтой санал гаргагч, загвар зохион бүтээгчийн шагнал болон түүнтэй адилтгах орлогын дүнгээр;

6/ урлагийн тоглолт, биеийн тамир, спортын уралдаан, тэмцээний шагналын орлогын дүнгээр;

7/ бооцоот болон тааварт тоглоом, хонжворт сугалааны хонжворын орлогын дүнгээр;

8/ бусад орлогын дүнгээр.

### **6 дугаар зүйл. Хувийн мал бүхий иргэний албан татвар ногдуулах малын тоог тодорхойлох**

Хувийн мал бүхий иргэний албан татвар ногдуулах малын толгойн тоог хонин толгойд шилжүүлэн тодорхойлно. Татварын тооцоонд үхэр, адуу, тэмээ тус бүрийг 5 хонь, 1 ямааг 1.5 хонь гэж тооцно. Төсвийн жилд орлогын албан татвар ногдуулах малын тоог тодорхойлохдоо өмнөх жилийн эцэст тоологдсон малын тоог үндэс болгоно. /2000 оны 11 дүгээр сарын 17-ны хуулиар нэмсэн/

### **7 дугаар зүйл. Албан татварын хэмжээ**

1.Монгол Улсад байнга оршин суугч татвар төлөгчийн энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 3, 4, 9, мөн хэсгийн 5 дахь заалтын “в”-д заасан орлогын жилийн дүнд дараахь хэмжээгээр тооцож албан татвар ногдуулна:

Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хувь, хэмжээ
0-2400000	10 хувь
2400001-4800000	240000 төгрөг дээр 2400000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 20 хувийг нэмнэ
4800001, түүнээс дээш	720000 төгрөг дээр 4800000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 30 хувийг нэмнэ

/ Энэ хэсэгт 2001 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар орсон өөрчлөлтийг тусгав./

2. /Үндсэн хуулийн Цэцийн 1993.3.13-ны өдрийн 2 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон./

3. Гадаадад ажиллаж байгаа Монгол Улсын иргэний төрөөс авдаг цалин, хөдөлмөрийн хөлсний орлогод ногдуулах татварын хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоож байна.

4. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгчид татвар ногдуулах журмыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоож байна. /2002 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

5. Аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнд олгосон дараахь орлогод дор дурдсан хувиар албан татвар ногдуулж дундын суутгал хийнэ:

а/ Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн “б”-д заасан орлогыг олгохдоо 10 хувиар;

б/ бараа, материал, түүхий эд худалдаж авахдаа үнийн дүнгийн 3 хувиар; Энэ заалт нь түүхий ноос, ноолуур, арьс ширэнд хамаарахгүй. /Энэ заалтад 2001 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар орсон нэмэлтийг тусгав./

Аж ахуйн нэгж, байгууллага суутгасан албан татварыг төсөвт шилжүүлж, энэ тухай орлого, татвар тодорхойлох хуудсанд тэмдэглэл хийж баталгаажуулна;

## **8 дугаар зүйл. Албан татварын тусгайлан ногдуулах хувь, хэмжээ**

Албан татварыг дараахь хувь, хэмжээгээр тусгайлан ногдуулна:

1/ шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл зохиогч, шинэ бүтээл, оновчтой санал гаргагч, загвар зохион бүтээгч нарын шагнал болон адилтгах бусад шагналын 5000000 хүртэлх төгрөгийн орлогод 5 хувиар, 5000001, түүнээс дээш төгрөгийн орлогод 10 хувиар; /Энэ заалтыг 2001 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./



2/ Энэ заалтыг 1997.4.17-ны хуулиар хүчингүй болсонд тооцов.]

3/ үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогын дүнд 2 хувиар;

4/ хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлогод 15 хувиар, зээлийн болон хадгаламжийн хүүгийн орлого, адилтгах бусад орлогод 15 хувиар;

5/энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлсон хонин толгой тутамд дор дурдсан хэмжээгээр татвар ногдуулна:

Аймаг, нийслэл	Татварын хэмжээ /төгрөг/
Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Улаанбаатар, Орхон	100
Архангай, Баянхонгор, Булган, Говь-сүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий	75
Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Завхан	50

/2000 оны 11 дүгээр сарын 17-ны хуулиар нэмсэн/

6/ бооцоот болон тааварт тоглоом, хонжворт сугалааны хонжворын орлогод 10 хувиар;

7/ урлагийн тоглолт, биеийн тамир, спортын уралдаан, тэмцээний шагналын орлогод 10 хувиар;

8/ эрхийн шимтгэлийн орлогод 10 хувиар;

9/ гадаад оронд эмнэлэг болон урлаг, уран сайхан, эрдэм шинжилгээ, сурталчилгаа зэрэг оюуны үйлчилгээ явуулсан иргэний уг орлогод Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол 10 хувиар;

10/ Монгол Улсад байнга оршин суугч нь татвар төлөгчийн дугаараа орлого олгогчид тэмдэглүүлээгүй бол түүний энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8 болон 7 дугаар зүйлийн 5-д заасан орлогод энэ хуулийн 8<sup>1</sup> дүгээр зүйлд заасан хувиар албан татвар ногдуулна.

## 9 дүгээр зүйл. Албан татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх

1. Албан татвар төлөгчийн дараахь орлогыг албан татвараас чөлөөлнө:

1/ Энэ заалтыг 1997.4.17-ны өдрийн хуулиар хассан.

2/ Хуульд заасны дагуу олгож байгаа тэтгэмж, нөхөн олговор,

төлбөр, Алдарт эхийн 1, 2 дугаар зэргийн одонгийн шагнал, ардын хувьсгалын партизаны тэтгэвэр, 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайнд оролцогчдод олгох тэтгэмж, хүүхдийн тэтгэлгийн орлого; /Энэ заалтад 2001 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар орсон нэмэлт, өөрчлөлтийг тусгав./

3/Монгол Улсын төрийн болон нэрэмжит шагнал, Засгийн газрын шагнал, Монгол Улсын ардын буюу гавьяат цолтны шагнал, нээлтийн шагнал, донорт болон эхийн сүүнд олгож буй нөхөн олговор, томилолтоор ажиллах хугацааны зам хоногийн зардалд олгосон мөнгө;

4/ даатгалын нөхцөлөөр олгож буй хохирол нөхсөний орлого; /Энэ заалтад 2001 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар орсон өөрчлөлтийг тусгав./

5/ Засгийн газрын зээллэгийн нөхөн олговор болон хүүгийн орлого;

6/ хууль тогтоомжийн дагуу олгож байгаа хөдөлмөр хамгааллын хувцас, хор саармагжуулах ундааны үнэ, дүрэмт хувцас, тэдгээртэй адилтгах бусад хангамжийн өртөг, гэнэтийн аюул, онцгой нөхцөл байдлын улмаас Засгийн газрын болон орон нутгийн байгууллага, улаан загалмайн нийгэмлэг, гадаад орнуудаас иргэдэд үзүүлж буй тусламж;

7/малбүхий өрхийн гишүүн бүрт хонин толгойд шилжүүлснээр 20 бог. Тухайн жилд албан татвар ногдуулах мал нь байгалийн гамшиг, гэнэтийн аюул, гоц халдварт өвчний улмаас хорогдсон бол зохих баримтыг үндэслэн татвар ногдуулах нийт малын тооноос хасч тооцно. /2000 оны 11 дүгээр сарын 17-ны хуулиар нэмсэн/

8/ Энэ заалтыг Монгол Улсын 1997 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

9/ Энэ заалтыг Монгол Улсын 1997 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

10/ Монгол Улс дахь дипломат төлөөлөгчийн буюу консулын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагад ажиллаж байгаа гадаадын иргэний орлого; /Энэ заалтад 2001 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар орсон нэмэлтийг тусгав./

11/энэ хэсгийн 10 дахь заалтад заасан ажилтан болон түүний гэр бүлийн гишүүдийн гадаад дахь эх үүсвэрээс олсон орлого;

12/ иргэд өөрсдийн орлого болон банкнаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар хувьдаа орон сууцны барилга барих, худалдан авахад зориулсан хөрөнгөтэй тэнцэх хэмжээний орлогыг зөвхөн тухайн жилийн татвар ногдох орлогоос хасч хөнгөлөлт үзүүлнэ;

13/ их, дээд болон тусгай мэргэжлийн сургуульд суралцагч хүүхдийн сургалтын төлбөрийн төлсөн дүнг дотоодын тухайн мэргэжлийн сургуулийн сургалтын төлбөрийн жишгээр бодон, иргэний тухайн жилийн татвар ногдох орлогоос хасч, хөнгөлөлт үзүүлнэ.

14/иргэдээс боловсролын сан, нийгэмд үйлчилдэг, улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагад өргөсөн хандив. /Энэ заалтыг 1998 оны 1 дүгээр сарын 15-ны хуулиар нэмсэн./

2. /Энэ хэсгийг 1997.4.17-ны хуулиар хүчингүй болсонд тооцсон./

3. Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан орлогод ногдох жилийн татвараас 48000 төгрөгийн татварыг хөнгөлнө. /Энэ хэсэгт 2001оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

4. Үр тариа, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлж байгаа Монгол Улсад байнга оршин суугчийн зөвхөн эдгээр үйлдвэрлэлээс олсон орлогод ногдох албан татварыг 50 хувиар хөнгөлнө.

## **10 дугаар зүйл. Албан татвар ногдуулах, төсөвт төлөх**

1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 3, 4, 9 дэх заалт, мөн хэсгийн 5 дахь заалтын “в”-д заасан орлогод 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь, хэмжээгээр албан татвар ногдуулна.

Аж ахуйн нэгж, байгууллага нь иргэнд орлого шилжүүлэх бүрдээ албан татварыг тооцон суутган авч энэ тухай орлого, татвар тодорхойлох хуудсанд тэмдэглэл хийж баталгаажуулна.

Хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг иргэний цалин, хөдөлмөрийн хөлсөнд ногдох албан татварыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага сарын эцэст суутган авна. Энэ тухай жилийн эцэст болон татвар төлөгч шилжих бүрд орлого, татвар тодорхойлох хуудсанд нь тэмдэглэл хийж баталгаажуулна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс суутган авсан албан татварыг дараа сарын 10-ны дотор төсөвт шилжүүлнэ.

Тухайн сард суутган авсан албан татварын хэмжээ нь 10000 төгрөгнөөс бага байвал суутган авсан уг албан татварыг дараа сарын албан татвартай нэгтгэн төсөвт шилжүүлнэ. /Энэ хэсэгт 2001 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

2. Арилжааны банк иргэний хадгаламжид хүү бодох бүрдээ энэ хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх заалтад заасан хувиар албан татвар ногдуулан суутган авч, төсөвт шилжүүлнэ.

/2, 3, 4 дэх хэсгийг 1997.4.17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон. 2001 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар 2 дахь хэсгийг нэмсэн./

5. Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл зохиогч, шинэ бүтээл, оновчтой санал гаргагч, загвар зохион бүтээгчийн шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого, бооцоот болон тааварт тоглоом, хонжворт сугалааны хонжворын орлого, урлагийн тоглолт, биеийн тамир, спортын уралдаан, тэмцээний шагнал олгож байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн нь тухайн орлогод энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1, 6, 7 дахь заалт болон 8<sup>1</sup> дүгээр зүйлд заасан хувиар албан татвар ногдуулан суутган авч, 3 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ.

6. Хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлого, зээлийн болон хадгаламжийн хүүгийн орлого, адилтгах бусад орлого, эрхийн шимтгэлийн орлого олгож байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн нь тухайн орлогод энэ хуулийн 8 дугаар зүйлийн 4, 8 дахь заалт болон 8<sup>1</sup> дүгээр зүйлд заасан хувиар албан татвар ногдуулан суутган авч, 3 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ.

7. Албан татвар төлөгч дараахь орлогод албан татвар өөрөө ногдуулан дор дурдсан хугацаанд төлнө:

1/ Хувийн мал бүхий иргэн албан татвараа 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны дотор хоёр хуваан төсөвт төлнө. Татварын алба татвар төлөгчтэй тохиролцсоноор албан татварыг урьдчилан төлүүлж болно.

Хувийн мал бүхий иргэн албан татвараа мал сүрэг нь байнга байгаа нутаг дэвсгэрийн орон нутгийн төсөвт төлнө;

2/ үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогод ногдох албан татварыг дараа улирлын эхний сарын 15-ны дотор;

3/ хөрөнгө түрээслүүлсний орлогод ногдох албан татварыг дараа улирлын эхний сарын 15-ны дотор;

4/ Энэ заалтыг 1997.4.17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

5/ аж ахуй эрхлэгч өөрийн орлогод энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь, хэмжээгээр улирал тутам албан татвар ногдуулан дараа улирлын эхний сарын 15-ны дотор төсөвт төлнө;

8. татвар төлөгч энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 3, 4, 9, мөн хэсгийн 5 дахь заалтын “в”-д заасан орлого авдаг бол уг орлогод энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувиар албан татвар ногдуулан төлж, орлого, татвар тодорхойлох хуудсаар албан татварын жилийн эцсийн тооцоо хийнэ.

## 11 дүгээр зүйл. Албан татварын тайлан тушаах хугацаа

1. Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор өссөн дүнгээр гаргаж, харьяалагдах татварын албанд тушаана.

2. Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 2 дахь заалтад заасан албан татварын тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж, харьяалагдах татварын албанд тушаана.

3. Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан орлого, татвар тодорхойлох хуудсыг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор татварын албанд тушаана.

4. Орлого, татварын тайлан болон орлого, татвар тодорхойлох хуудасны маягт, түүнийг хэрэглэх зааврыг Үндэсний татварын ерөнхий газар батална.

5. Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан албан татварын тайланг дараа улирлын эхний сарын 10-ны дотор гаргаж, харьяалагдах татварын албанд тушаана..

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИАС

## 15 дугаар зүйл. Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, төлөх хугацаа

1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө:

Даатгалын төрөл	Төлөх шимтгэл хувь хэмжээ /хувиар/	
	ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос	даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос
1/тэтгэврийн даатгал	13.5	5.5
2/тэтгэмжийн даатгал	1.0	1.0
3/үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	1.0, 2.0 ба 3.0	-
4/ажилгүйдлийн даатгал	0.5	0.5

2. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дор дурдсан хувиар тооцсон дүнгээс багагүй байна:

1/тэтгэврийн даатгал 9,5 хувь

2/тэтгэмжийн даатгал 1,0 хувь

3/үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал 1,0 хувь

3. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл /хураамж/-ийн хувь хэмжээг Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулиар тогтооно.

4. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хамаарагдах даатгуулагчийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг ажил олгогч бүрэн төлнө.

5. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байдлаас нь хамааралтайгаар энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр ялгавартай төлөх ажил олгогчийн жагсаалтыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална.

6. Ажлын байрны нөхцлийн ажиллагчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйлийг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагын хүрээнд шийдвэрлэх боломжгүй, түүнчлэн хөдөлмөрийн халуун, газрын доорх нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

Та энэхүү гарын авлагын талаар санал сэтгэгдлээ  
Нээлттэй Нийгэм Форум, Жамъян гүний гудамж-5/1,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48, Монгол Улс хаягаар бичнэ үү.

---

Та энэхүү гарын авлагын талаар санал сэтгэгдлээ  
Нээлттэй Нийгэм Форум, Жамъян гүний гудамж-5/1,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48, Монгол Улс хаягаар бичнэ үү.

---











